



Canada

**2016 ОНЫ  
УЛСЫН ИХ ХУРЛЫН СОНГУУЛЬ**

**СОНГУУЛИЙН  
САНХҮҮЖИЛТИЙН  
МОНИТОРИНГ**

**2016 PARLIAMENTARY ELECTIONS  
CAMPAIGN FINANCE MONITORING**

Улаанбаатар хот  
2016

**2016 ОНЫ  
УЛСЫН ИХ ХУРЛЫН СОНГУУЛЬ  
СОНГУУЛИЙН САНХҮҮЖИЛТИЙН МОНИТОРИНГ**

---

Судалгааны тайланг эмхэтгэж бичсэн Д. ЭНХЦЭЦЭГ  
ННФ-ын Засаглалын хөтөлбөрийн менежер

Мэдээлэл цуглуулсан мониторингийн багийн ахлагч З. УЯНГА  
«Филантропи» Хөгжлийн төлөө ТББ-ын хуульч

Энэхүү мониторингийн ажлыг Нээлттэй Нийгэм Форум, Бүгд Найрамдахчуудын Олон Улсын Хүрээлэн, Канадын Гадаад хэргийн яамны дэмжлэгтэйгээр «Филантропи» Хөгжлийн төлөө ТББ тэргүүтэй Монголын иргэний нийгмийн байгууллагууд хамтран хэрэгжүүлэв. Мониторингийн үр дүн болон тайлангийн агуулга нь Бүгд Найрамдахчуудын Олон Улсын Хүрээлэнгийн, эсвэл Канад Улсын Засгийн газрын албан ёсны байр суурь биш болно.

This monitoring project was conducted by «Philanthropy»-Center for Development NGO with the support of the OSF, International Republican Institute and Global Affairs Canada. The findings and opinions expressed herein do not necessarily reflect the views of the International Republican Institute or the Government of Canada.

© Нээлттэй Нийгэм Форум, 2016  
Уг тайланг ашиглахдаа эх сурвалжийг дурдана уу.  
ДАА 320  
ННА 66

ISBN: 978-99978-803-0-7

Хаяг: Жамьян гүний гудамж  
Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар-14240  
Утас: 976-11-313207  
Факс: 976-11-324857  
Вэб: <http://www.forum.mn>  
И-мэйл: [osf@forum.mn](mailto:osf@forum.mn)

Энэхүү тайланд мониторингийн үзэр сонгосон тойргуудад авсан гэрэл зургуудыг ашиглав.

## **ГАРЧИГ**

Өмнөх үг	4
Товчилсон нэр	6
Хураангуй	7

## **ТАНИЛЦУУЛГА** 11

Мониторинг хийх үндэслэл	11
Мониторингийн зорилго, зорилт, хамрах хүрээ	15
Мониторингийн аргачлал	16
Төслийн баг	18

## **ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН ОРЧИН** 19

Сонгуулийн хандив	20
Сонгуулийн зардлын данс	21
Сонгуулийн зардлын дээд хэмжээ ба зардлын зориулалт	22
Сонгуулийн зардлыг бууруулахад чиглэсэн зохицуулалтууд	22
Төрийн эх үүсвэрийг ашиглахтай холбоотой зохицуулалт	23
Сонгуулийн санхүүжилтийн тайлагналт, хяналт	23
Сонгуулийн санхүүжилтийн ил тод байдлыг зохицуулсан байдал	25

## **МОНИТОРИНГИЙН ДҮН** 27

Сонгуулийн зардлын ерөнхий дүр зураг	27
Мониторингид хамрагдсан 7 тойргийн нэр дэвшигчдийн сонгуулийн санхүүжилтийн мэдээлэл	31

## **ДҮГНЭЛТ** 53

## **ЗӨВЛӨМЖ** 56

## **ХАВСРАЛТУУД** 58

## ӨМНӨХ ҮГ

---

Монгол Улс 1992 онд баталсан Үндсэн Хуульдаа Монгол Улсад засгийн бүх эрх мэдэл ард түмний гарт байна гэж тунхагласан. Ардчиллын амин сүнс болсон засаглалын энэ зарчим хэрэгжих үндэс нь ард түмний сонгох, сонгогдох эрх бүрэн утгаараа хангагдсан чөлөөт шударга сонгууль юм. Харин чөлөөт, шударга сонгуулийн нэг гол зарчим нь ил тод байдал бөгөөд энэ зарчим нэн тэргүүнд хамаарах ёстой чухал асуудал бол сонгуулийн санхүүжилт мөнөөс мөн. Улс төрийн санхүүжилт, түүн дотор сонгуулийн санхүүжилтээр дамжсан авлигын асуудал нь олон нийтийн эрх ашгийг ноцтой хохироож, төрд итгэх итгэлийг нь бууруулах гол хүчин зүйл болж байгааг сүүлийн үеийн судалгааны үр дүн харуулж байна. Тухайлбал, 2014 онд ННФ-аас Сант Марал сантай хамтран хийсэн «Намуудын санхүүжилтийн талаарх олон нийтийн санал бодлын судалгаа»-нд оролцсон хот хөдөөгийн 1200 иргэний 79 хувь нь «өнөөгийн улс төрийн санхүүжилтийн тогтолцоо нь тодорхой сонирхлын бүлэгт давуу байдал олгож байна» гэсэн бол 74 хувь нь «сонгуулийн өрсөлдөөнийг бууруулж байна» гэж үзсэн ба 86% нь» энэ салбарт томоохон шинэчлэл шаардлагатай» гэж хариулсан байдаг. Уг салбарт зайлшгүй шаардлагатай байгаа шинэчлэлийг дэмжиж, оролцогч талуудыг мэдээллээр хангах зорилгоор Нээлттэй Нийгэм Форум (ННФ), Шударга сонгуулийн төлөө иргэний нийгмийн сүлжээний гишүүн байгууллагууд хамтран УИХ-ын сонгуулийн үйл явцад 2004 оноос эхлэн ажиглалт-мониторинг хийж ирсэн туршлагадаа үндэслэж 2016 оны УИХ-ын сонгуулийн санхүүжилтэд мониторинг хийлээ.

2016 оны УИХ-ын сонгууль нь нэг мандаттай 76 жижиг тойргууд бүхий мажоритар системээр явагдаж шинээр баталсан Сонгуулийн тухай хуульд анх удаа нам, эвсэл, нэр дэвшигчид нь иргэн болон хуулийн этгээдээс авч буй хандиваа сонгуулиас өмнө ил тод тайлагнах заалтууд тусгалаа олсон билээ. Мөн нэр дэвшигч бүр хөрөнгө орлогын мэдүүлгээ Сонгуулийн Ерөнхий Хороо (СЕХ)-нд гаргаж өгч байж нэр дэвших эрх нь баталгаажих болсон.

Сонгуулийн санхүүжилтийн ил тод байдлыг хангахтай холбоотой хууль тогтоомжийн хэрэгжилтийг хянах ерөнхий зорилгын хүрээнд уг мониторингийг явуулахдаа сонгогчдын тоо, алслагдмал байдал, нэр дэвшигчдийн өрсөлдөөнт байдлыг харгалзан Улаанбаатар хотоос 4, хөдөө орон нутгаас 3 тойргийг сонгосон ба сонгуулийн зардлын талаар нарийвчилсан мэдээлэл цуглуулахдаа дээрх тойрогт нэр дэвшсэн 21 нэр дэвшигчийг сонгожээ. Тэдгээр нэр дэвшигчийн сонгуулийн сурталчилгааны нийтдээ 150 гаруй арга хэмжээнд байлцан ажиглалт хийсэн ба ийнхүү ажиглалт хийхэд сонгуулийн хууль тогтоомжийг илт зөрчсөн үйлдэл илрээгүй нь сайшаалтай. Гэвч сонгуульд оролцсон улс төрийн нам, нэр дэвшигчдийн санхүүжилтийн ил тод байдал, хяналт ямар түвшинд байгааг үнэлж үзэхэд хуулийн хэрэгжилт туйлын хангалтгүй, мэдээлэл хаалттай байгааг мониторингийн дүн харуулж байна.

Сонгуулийн санхүүжилтийг ажигласан энэхүү тайлан нь цар хүрээний хувьд сонгуулийн санхүүжилтийн асуудлыг иж бүрнээр нь авч үзсэн анхны судалгаа болох тул сонирхсон уншигч улс төрийн намынхан, нэр дэвшигчид, холбогдох төрийн байгууллагын ажилтнууд, судлаачид, иргэний нийгмийн ажиглагчдад ач холбогдолтой эх сурвалж болно гэж найдаж байна. Түүнчлэн цаашид Сонгуулийн хуулийг боловсронгуй болгоход энд гарч буй Зөвлөмж тус дэм болно гэдэгт итгэж байна.

Төгсгөлд нь уг мониторинг хийхэд санхүүгийн дэмжлэг үзүүлсэн Бүгд Найрамдахчуудын Олон Улсын Хүрээлэн, Канадын Гадаад хэргийн Яам, хамтарч хэрэгжүүлсэн «Филантропи» Хөгжлийн төлөө ТББ болон бусад иргэний нийгмийн байгууллагууд, ажиглагчид, мөн энэхүү тайланг нэгтгэж боловсруулсан ННФ-ын Засаглалын хөтөлбөрийн менежер Д. Энхцэцэгт гүн талархал илэрхийлье.

ННФ-ын Гүйцэтгэх Захирал П. Эрдэнэжаргал

## Товчилсон нэр

АН	Ардчилсан нам
АТГ	Авлигатай тэмцэх газар
ДНБ	Дотоодын нийт бүтээгдэхүүн
МАН	Монгол ардын нам
МАХН	Монгол ардын хувьсгалт нам
НҮБХХ	Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хөгжлийн Хөтөлбөр
СЕХ	Сонгуулийн ерөнхий хороо
УИХ	Улсын Их Хурал
ТББ	Төрийн бус байгууллага
ҮАГ	Үндэсний аудитын газар

## ХУРААНГУЙ

---

Улс төрийн нам нь нэг талаас үзэл бодлоороо эвлэлдэн нэгдсэн хувь хүмүүсийн байгууллага мэт боловч нөгөө талаас сонгуульд оролцож засаглах эрх мэдэл болон түүнд оролцох эрх авах, төрийн бодлогыг тодорхойлох, төрийн албан тушаалд өөрсдийн хүмүүсийг бэлтгэн байршуулах улс төр, үзэл суртлын болоод нийгмийн онцгой чухал үүрэг хүлээдэг институци билээ. Сонгуулиар төрийн эрх мэдлийг хэрэгжүүлэх мандат олж авсан нам, нэр дэвшигч ард түмний эрх ашгийг ямагт тэргүүнд тавьж ажиллах ёстой. Харин энэхүү баталгааг хангах үүднээс улс төрч болоод улс төрийн хүчнүүд хаанаас, ямар эх үүсвэрээс санхүүжиж байгааг мэдэх зүй ёсны эрх сонгогчдод бий.

Монгол Улс ардчилсан сонгуулийн арга замаар төрийн эрх барих дээд байгууллагаа байгуулж ирсэн сүүлийн хорь гаруй жилийн хугацаанд улс төрийн намууд болоод нэр дэвшигчдийн сонгуульд зарцуулах мөнгөний хэмжээ өссөөр хэдэн арван тэрбумаар тоологдох болсон ч энэ их мөнгө ямар эх үүсвэрээс гаралтай, юунд зарцуулагдаж байгаа талаар сонгогчдод хүрэх мэдээлэл маш хомс байна. Чухам ийм хаалттай байдал нь улс төрийн хүрээний буюу өндөр түвшний авлига газар авах нэг нөхцөл болдог талаар гадаад, дотоодын эрдэмтэн судлаачид анхааруулан сануулсаар иржээ.

2016 оны УИХ-ын ээлжит сонгуулиар улс төрийн нам, эвсэл, нэр дэвшигчдийн сонгуулийн санхүүжилтийн мэдээллийг ил тод болгож сонгогчдыг мэдээллээр хангах, энэ асуудлаарх эрх зүйн орчныг сайжруулахад хувь нэмэр оруулах зорилгын хүрээнд «Шударга сонгуулийн төлөө» иргэний нийгмийн сүлжээний гишүүн байгууллагууд хамтран «Филантропи» Хөгжлийн төлөө төв ТББ-ын удирдлага, зохион байгуулалт дор энэхүү мониторингийн төслийг хэрэгжүүллээ. Төслийг хэрэгжүүлэхэд Нээлттэй Нийгэм Форум, Бүгд Найрамдахчуудын Олон Улсын Хүрээлэн, Канадын Гадаад хэргийн яам дэмжлэг үзүүлсэн болно.

2016 оны оны УИХ-ын сонгуульд нийт 12 нам, 3 эвсэл, 498 нэр дэвшигч оролцсон бөгөөд Үндэсний Аудитын Газрын гаргасан мэдээллээс үзэхэд сонгуулийн зардлын тайлангаа ирүүлсэн 11 нам, 2 эвсэл сонгуулийн зорилгоор нийт 8,4 орчим тэрбум төгрөг төвлөрүүлснээс 8,3 тэрбумыг зарцуулжээ. Харин 498 нэр дэвшигчээс зөвхөн 386 нь сонгуулийн зардлын тайлангаа хуульд заасны дагуу ирүүлсэн байх агаад тэдний зардлын нийт дүн 26 тэрбум гаруй төгрөг болжээ. Нам, эвсэл, нэр дэвшигчдийн зардал нийлээд 34,4 тэрбум төгрөг болж байна.

Мониторингийн хүрээнд сонгуулийн санхүүжилтийн ил тод байдлыг 3 үе шаттайгаар буюу сонгуулийн өмнөх үе, сонгуулийн кампанит ажлын үе, санал хураалт явагдсан өдрөөс хойших үе гэж ангилан хуулийн хэрэгжилтэд бие даасан хяналт тавьж ажиллав. Ийнхүү мониторинг хийхэд сонгуулийн бүхий л үе шатанд улс төрийн нам, эвсэл, нэр дэвшигчдийн санхүүжилтийн мэдээлэл ил тод бус, түүнд тавих хяналт хангалтгүй байгаа нь харагдлаа.

Тухайлбал:

- 2015 онд баталсан Сонгуулийн тухай хуулиар анх удаа сонгуульд оролцохоор хүсэлт гаргаж буй улс төрийн нам, эвсэл сүүлийн нэг жилийн хугацаанд иргэн, хуулийн этгээдээс хүлээн авсан хандивын тайлангаа, нэр дэвшигчдийн хувьд хөрөнгө орлогын мэдүүлгээ СЕХ-нд хүлээлгэн өгөх болсон нь сонгуулийн дараа хагас дутуу байдлаар ил болдог байсан сонгуулийн санхүүжилтийн мэдээллийг сонгуулиас өмнө ил тод, хяналттай болгоход чиглэсэн дэвшилттэй алхам болсон. Монгол Улсад хүчин төгөлдөр хэрэгжиж буй холбогдох хуулиудын хүрээнд дээрх мэдээлэл ил байх ёстой. Гэвч үр дүнгээс үзэхэд дээрх мэдээллийг холбогдох төрийн байгууллагаас авах хүсэлт гаргахад цааргалах хандлага гаргаж мэдээллийг нууцалж байв.
- 2016 оны УИХ-ын сонгуулийг нэг мандаттай жижиг тойргуудаар зохион байгуулсан бөгөөд энэ нөхцөлд нэр дэвшигчдийн гүйцэтгэх үүрэг оролцоо өндөр болно. Сонгуулийн хуулийн хүрээнд нэр дэвшигчдийн хамгийн идэвхтэй ажиллаж сонгуулийн зорилгоор хөрөнгө босгож, зарцуулах хугацаа нь сонгуулийн кампанит ажлын үе юм. Мониторингийн багийн зүгээс хот хөдөөгийн нийт 7 тойрогт УИХ-д суудалтай АН, МАН, МАХН гурван



намын 21 нэр дэвшигчийн зохион байгуулсан 150 гаруй сонгуулийн сурталчилгааны арга хэмжээнд байлцаж хяналт тавихад Сонгуулийн хуулийг илт зөрчсөн буюу төрийн унаа ашиглах, төрийн албан хаагчийг дайчлах, сонгогчдын санал худалдан авах зөрчил ажиглагдаагүй болно. Гэвч сонгуулийн сурталчилгаанд зарцуулж буй зардалтай холбоотой мэдээлэл олж авах нь маш бэрхшээлтэй байлаа. Энэ талаар мэдээлэл авах хүсэлт гаргахад нэр дэвшигчдийн дийлэнх хувь нь цааргалж татгалзсан хариулт өгч байв. Үүний улмаас сонгогчдын хувьд мэдээлэл хамгийн их хэрэгтэй сонгуулийн кампанит ажлын үе нь мэдээлэл хамгийн хаалттай үе болж таарч байна.

- 2016 оны УИХ-ын сонгуулиас эхлэн СЕХ-ны оронд Төрийн аудитын байгууллага сонгуульд оролцсон нам, эвсэл, нэр дэвшигчдийн зардлын тайланг хянаж эхэлсэн ба энэ үүргээ хэрэгжүүлэхтэй холбоотой ямар эрх эдлэхийг хуульд тодорхой зааж өгчээ. Гэвч энэ эрх, үүргээ бүрэн гүйцэд хэрэгжүүлж, сонгуулийн зардлын тайланд иж бүрэн хяналт тавьж буй эсэх нь эргэлзээтэй байна. Тухайлбал, улс төрийн нам, эвсэл, нэр дэвшигчдийн Төрийн аудитын байгууллагад хүлээлгэн өгч буй зардлын тайланг авч үзэхэд зарцуулалтын хувьд эргэлзээ төрүүлэхүйц жишээ баримт нэлээд байна. Жишээ нь: Орон нутгийн тойрогт нэр дэвшсэн, Улаанбаатарт оршин суудаг нэр дэвшигчид унаа, шатахууны зардал огт тайлагнаагүй байхад тухайн орон нутагтаа байнга оршин суудаг нэр дэвшигч сонгуулийн сурталчилгааны 17 хоногийн хугацаанд 54 сая гаруй төгрөгийг шатахуунд зарцуулсан гэж тайлагнасан байв. Энэ мэтчилэн тайлбар шаардсан жишээ олон байвч Төрийн аудитын байгууллагын сонгуулийн зардлын тайланд хяналт хийсэн тухай мэдээлэлд зардлын дансанд цугласан хөрөнгө, зардлын ерөнхий дүн, хуульд заасан хэмжээнээс дээш дүнтэй хандив өгсөн хувь хүмүүс, хуулийн этгээдийг нэрийг жагсааснаас өөр мэдээлэл алга байна.
- Түүнчлэн зардлын тайлангийн хуулбарыг хуульд заасны дагуу татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлж буй ч зардлын тайланг хүлээж аваад ямар түвшинд хяналт тавьдаг, төрийн аудитын байгууллагатай хэрхэн хамтарч ажилладаг нь тодорхой биш байна.

Мониторингийн үр дүн, дүгнэлтэд үндэслэн дараах ерөнхий Зөвлөмжийг гаргалаа:

- Сонгуулийн зардлын дансыг шилэн болгох шаардлагыг хуульд тусгах;
- Сонгуулийн дараа зардлын дансны тайланг гаргах журам, зааврыг нарийвчлан тодорхой гаргах үүргийг Төрийн аудитын байгууллагад хариуцуулах, ингэхдээ Монгол Улсын Нягтлан бодох бүртгэлийн хуульд нийцүүлэн, зардлуудыг баримтжуулан тайлагнадаг байх шаардлага тавьж, тайлангийн загвар, стандартыг сайжруулах;
- Мөнгөн бус хандивыг дэлгэрэнгүй баримттай тайлагнах талаар тодорхой заавар, тайлангийн маягт, загвар гаргаж мөрдүүлэх;
- Зардлын тайланд хяналт тавих үүрэг хүлээсэн төрийн байгууллагууд хэрхэн үйл ажиллагаагаа уялдуулж, иж бүрэн хяналт тавих талаар хуульд тодорхой заах;
- Сонгуулийн өмнө болон явцад, түүнчлэн сонгууль дууссаны дараа санхүүжилтийн мэдээллийг ил тод, нээлттэй болгох механизм, арга хэлбэрийг тодорхой зааж, хэрэгжилтийг хангахад анхаарах.



## ТАНИЛЦУУЛГА

---

### Мониторинг хийх үндэслэл


#### *Сонгуулийн санхүүжилт ба түүнд хяналт тавихын ач холбогдол*

Ардчилсан сонгуулийн нэг гол зарчим нь сонгуульд өрсөлдөж буй улс төрийн нам, эвсэл, нэр дэвшигчид тэнцвэртэй бөгөөд тогтвортой эрх зүйн орчинд тэгш гарааны зарчмаар шударга өрсөлдөх боломжтой байх явдал билээ. Сонгуульд өрсөлдөх талууд хэвлэл мэдээллийн хэрэгсэл ашиглах, уулзалт цуглаан зохион байгуулах, ухуулах байр ажиллуулах гэх мэт хуулиар зөвшөөрсөн янз бүрийн арга хэрэгсэл ашиглан мөрийн хөтөлбөрөө сонгогчдод чөлөөтэй тайлбарлан хүргэх бололцоотой байхын зэрэгцээ энэ үйл ажиллагаагаа санхүүжүүлэх орлогыг хуулиар зөвшөөрсөн эх үүсвэрээс хуримтлуулан зардлаа ил тод тайлагнах нь дээрх зарчим хэрэгжих чухал нөхцөл болдог.

Түүнчлэн санхүүгийн хувьд илт давуу оролцогч өрсөлдөгчдийнхөө дуу хоолойг дарж давамгайлахаас сэргийлэх, сонгогчдын саналыг худалдан авах, албан тушаалтнуудын хувьд төрийн эх үүсвэрийг ашиглаж давуу байдал тогтоохоос сэргийлэн хянах арга хэмжээ авах нь мөн шударга өрсөлдөөн, тэгш гарааны зарчмыг хангахад чухал нөлөөтэй.


Монгол Улс 1992 онд шинэ Үндсэн хуулиа баталснаас хойш Улсын Их Хурлын болон орон нутгийн сонгуулийг 7 удаа, Ерөнхийлөгчийн сонгуулийг 6 удаа зохион байгуулаад байна. Энэ хугацаанд улс төрийн намуудын сонгуульд зарцуулах зардлын хэмжээ тогтмол нэмэгдэж ирснийг судалгааны дүн харуулдаг. Харин энэ их хэмжээний мөнгө ямар эх үүсвэрээс бүрдэж, юунд зарцуулагдаж байгаа талаарх мэдээлэл хомс байх ба сонгуулийн санхүүжилтэд тавих хяналт маш сул байсаар өнөөг хүрчээ.

### Нэр дэвшигч болон намуудын кампанит ажлын нийт зардал (сая төгрөгөөр)



Эх сурвалж: Сонгогчдын боловсрол төв

## Нэг сонгогчид ногдох кампанит ажлын зардал (төгрөгөөр)



Эх сурвалж: Сонгогчдын боловсрол төв

Сонгуулийн кампанит ажлын санхүүжилт буюу сонгуулийн санхүүжилт ил тод бус, түүнд тавих хяналт сул байх нь авлига цэцэглэх таатай нөхцөл болдгийг олон улсын туршлага харуулдаг бөгөөд энэ асуудал Монгол Улсад ч газар аваад байгааг сүүлийн жилүүдэд хийгдсэн авлигын асуудлаарх албан ёсны судалгааны **Монгол Улсад өндөр түвшний авлига түгээмэл хэвээр байна.** Тухайлбал, Авлигатай тэмцэх газраас жил бүр гаргадаг «Улс төр, хууль хяналтын байгууллагын хүрээн дэх авлигын

Эх сурвалж: АТГ-ын 2014 оны судалгаа

талаарх шинжээчдийн төсөөллийн судалгаа»-ны 2014 оны тайланд Монголд өндөр түвшний авлига түгээмэл хэвээр байна гэж дүгнэсэн байна. Уг судалгаанд хамрагдсан шинжээчдийн 62.1 хувь нь улс төрийн авлига далд хэлбэрээр маш их байгааг онцолсон байх ба «улс төр, бизнесийн нэгдмэл ашиг сонирхол бүхий бүлэглэлүүд хоорондоо нэгдэж улс төрд нөлөөлөх болсон нь Монгол дахь 'өндөр' түвшний авлигын нэг хэлбэр болтлоо ноцтой байдалд хүрсэн болохыг» анхааруулжээ. Улмаар дээрх судалгаанд хамрагдагсдын 83.3 хувь нь нам доторх болон улс төрийн албан дахь албан тушаалын томилгоо, намын санхүүжилтийн механизм зэрэг хүчин зүйлс нь 2014 онд өндөр түвшний авлигад маш их болон их хэмжээгээр нөлөөлсөн хүчин зүйл гэж үзсэн нь мөн анхаарал татаж байна.

Улс төрийн хүрээний буюу өндөр түвшний авлигыг бууруулахад нэн тэргүүнд улс төрийн санхүүжилтийн ил тод байдлыг хангаж, хууль тогтоомжийг ягштал хэрэгжүүлэх, түүнд тавих хяналтыг чангатган, зөрчил илэрсэн тохиолдолд хүлээлгэх хариуцлагыг тодорхой болгох ёстой. Сонгуулийн санхүүжилт нь агуулгын хувьд улс төрийн санхүүжилтийн чухал бүрэлдэхүүн хэсэг бөгөөд энэ утгаараа түүний ил тод байдлыг хангаж хяналт тавих нь ардчилсан сонгууль төдийгүй засаглалын чанартай холбоотой нэн чухал асуудал болно.

### ***Сонгуулийн санхүүжилтийн ил тод байдал***

Сонгуулийн санхүүжилтийн ил тод байдалд дараах гол асуудлуудыг ерөнхийд нь хамруулж ойлгоно.

Хэн, юуг ил тод болгох вэ?

- Сонгуульд оролцож буй нам эвсэл, нэр дэвшигчид сонгуульд оролцох зорилгоор хүлээж авсан хандив, өөрийн хөрөнгөөс оруулсан болон бусад эх үүсвэрээс хуримтлуулсан мөнгөн болон мөнгөн бус орлогын хэмжээ
  - Эх үүсвэр (хандивлагчид, өөрийн хөрөнгө, зээл гэх мэт)
  - Хандивын хэмжээ (мөнгөн болон мөнгөн бус, хямдруулсан үнэтэй бараа үйлчилгээ гэх мэт)
  - Огноо (хэзээ хүлээж авсан)
- Зарцуулалт буюу зардлын тайлан (сонгуулийн кампанит ажилтай холбоотой ямар ажил, бараа, үйлчилгээ хаанаас, хэнээс ямар зорилгоор худалдаж авсан талаар шалгаж хянах боломжтой иж бүрэн мэдээлэл)

Хэнд дээрх мэдээллийг ил тод болгох вэ?

- Сонгуулийн санхүүжилтэд хяналт тавих чиг үүргийг хуулиар хүлээсэн төрийн холбогдох байгууллагуудад
- Сонгогчид, тэднийг төлөөлөн сонгуулийн үйл явцад хяналт тавьж буй иргэний нийгмийн байгууллагуудад
- Хэвлэл мэдээллийн байгууллагуудад

Хэзээ тайлагнах вэ?

- Сонгуулиас өмнө

- Сонгуулийн кампанит ажлын явцад тогтмол давтамжтайгаар
- Сонгуулийн дараа

Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хөгжлийн Хөтөлбөр (НҮБХХ) зэрэг олон улсын байгууллагуудын зөвлөснөөр сонгуулийн санхүүжилтийн ил тод байдлыг хангахгүйгээр хандивын хязгаар болон зардлын дээд хэмжээ тогтоох гэх мэт бусад арга хэмжээ авах замаар сонгуулийн санхүүжилтийг зохицуулах янз бүрийн оролдлого нь үр дүнд хүрдэггүй байна. Иймд олон улсад сонгуулийн санхүүжилтийн зохицуулалт, түүний хэрэгжилтийг авч үзэхдээ юуны өмнө ил тод байдлыг хэрхэн хангаж, хяналт тавьж байгааг голлон авч үзсээр иржээ.

## **Мониторингийн зорилго, зорилт, хамрах хүрээ**

2016 оны УИХ-ын сонгуулийн ил тод байдлыг хангах үндсэн зорилгын хүрээнд сонгуулийн санхүүжилтийн ил тод байдлыг хангахтай холбоотой хууль тогтоомжийн хэрэгжилтийг хянах, түүний үр дүнд тулгуурлан сонгуулийн санхүүжилтийг зохицуулсан эрх зүйн орчныг боловсронгуй болгох санал, зөвлөмж боловсруулах зорилгоор энэхүү мониторингийг явуулсан болно.

Мониторингийн хүрээнд дараах зорилтуудыг тавьж ажиллалаа. Үүнд:

- Сонгуулийн кампанит ажлын санхүүжилтийн мэдээллийг ил тод болгоход түлхэц үзүүлж сонгогчдыг мэдээллээр хангах
- Сонгуулийн кампанит ажлын зардалтай холбоотой хуулийн заалтуудын хэрэгжилтийг хянах
- Сонгуулийн кампанит ажлын санхүүжилтэд хяналт тавих үүрэгтэй төрийн байгууллагуудын үйл ажиллагааг үнэлэх
- Сонгуулийн зардлын дэлгэрэнгүй тайланг ил тод болгоход түлхэц үзүүлэх, тайланд дүн шинжилгээ хийх
- Сонгуулийн санхүүжилтийн ил тод байдлыг цаашид сайжруулах талаар зөвлөмж боловсруулах.

Мониторингид хамруулах тойргуудыг сонгохдоо сонгогчдын тоо, төвөөс алслагдсан байдал, амьдрах орчны нөхцөл (гэр хороолол болон орон сууцны хорооллын төлөөлөл), нэр дэвшигчдийн өрсөлдөөнт байдал зэргийг харгалзсан болно. Дээрх нөхцөлийг үндэслэн Улаанбаатар хотоос 4, хөдөө орон нутаас 3, нийтдээ 7 тойргийг

хамруулж эдгээр тойрогт нэр дэвшсэн УИХ-д суудалтай намууд болох Ардчилсан нам (АН), Монгол ардын нам (МАН), Монгол ардын хувьсгалт нам (МАХН)-ын нийт 21 нэр дэвшигчдийг хамруулав.



*УИХ-д нэр дэвшигчдийн статистик мэдээлэл*  
*Эх сурвалж: [www.eagle.mn](http://www.eagle.mn)*

### Мониторингид хамрагдсан тойргууд

д/д	Тойргийн байрлал	Тойрог
1	Улаанбаатар хот	Баянзүрх дүүргийн 49 дүгээр тойрог
2	Улаанбаатар хот	Баянзүрх дүүргийн 53 дугаар тойрог
3	Улаанбаатар хот	Сүхбаатар дүүргийн 60 дугаар тойрог
4	Улаанбаатар хот	Сүхбаатар дүүргийн 61 дүгээр тойрог
5	Төв аймаг	30 дугаар тойрог
6	Өмнөговь аймаг	22 дугаар тойрог
7	Өмнөговь аймаг	23 дугаар тойрог

## Мониторингийн аргачлал

Сонгуулийн санхүүжилтийн мониторингид холбогдох мэдээлэл цуглуулахдаа баримт бичигт дүн шинжилгээ хийх, ажиглалтын болон ярилцлагын аргуудыг сонгуулийн дараах үе шатуудын онцлогт нийцүүлэн ашиглав. Үүнд:

1. *Сонгуулиас өмнөх үе*: Намуудын хандивын болон зардлын тайлан, нэр дэвшигчдийн хөрөнгө орлогын мэдүүлгийн ил тод байдлыг



хянах зорилгын хүрээнд

- Мэдээллийн эрх чөлөөний хууль болон сонгуулийн хуулийн холбогдох заалтуудад үндэслэн Сонгуулийн ерөнхий хороо (СЕХ), Үндэсний аудитын газар (ҮАГ) болон бусад холбогдох газруудаас мэдээлэл хүсэх
  - Холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх
2. *Сонгуулийн кампанит ажлын үеэр:* Сонгуулийн зардлын талаар хуулийн заалтуудын хэрэгжилтэд хяналт тавих зорилтын хүрээнд нэр дэвшигчдийн сонгуулийн штабууд, нам, эвсэл, нэр дэвшигчдийн зохион байгуулж буй хурал цуглаан дээр ажиглалт хийн дараах мэдээллийг цуглуулах
- Төрийн өмчийн байр, тээврийн хэрэгсэл бусад эх үүсвэрийг ашиглаж буй эсэх
  - Сонгуулийн штабуудад ажиллаж буй менежер, ухуулагч, бусад хүмүүсийн тоо, цалин урамшуулал
  - Ухуулах байрны тоо, түрээсийн төлбөр
  - Зурагт болон ухуулах хуудас, сурталчилгааны самбарын тоо ширхэг, үнэ
  - Уулзалт зохион байгуулж буй танхим, бусад хэрэгсэлтэй холбогдон гарч буй зардал
3. *Сонгуулийн дараа:* Сонгуулийн зардлын тайлангийн ил тод байдал, түүнд төрийн холбогдох байгууллагуудын зүгээс тавьж буй хяналт ямар түвшинд байгааг үнэлэх
- Сонгуулийн кампанит ажил, санал худалдан авсан болон бусад зөрчил гаргасан тухай хууль, хяналтын байгууллагад гаргасан гомдол, мэдээлэл, тэдгээрийг шалгаж арга хэмжээ авсан талаарх мэдээллийг холбогдох төрийн байгууллагуудаас авах
  - Нам, нэр дэвшигчдийн зардлын тайланг хүлээн авч хянасан талаарх мэдээллийг Төрийн аудитын газраас авах, албан ёсны дүгнэлттэй танилцах, цуглуулсан мэдээлэлтэйгээ харьцуулж хянах
  - Дээр дурдсан асуудлаар баримт бичигт дүн шинжилгээ хийсний дараа холбогдох албаны хүмүүсээс ярилцлага авах замаар чанарын мэдээлэл цуглуулах.

## Төслийн баг

Нийт 50 гаруй гишүүнтэй төслийн баг дараах гурван үндсэн хэсэгт хуваагдан ажилласан болно. Үүнд:

1. Төслийн төв баг буюу Улаанбаатар хотын тойргуудад ажиглалт хийж, дүнг нэгтгэх баг
2. Төслийн орон нутгийн баг буюу Төв, Өмнөговь аймгийн сонгосон тойргуудад ажиглалт хийж мэдээлэл цуглуулах баг
3. Төслийн дүн шинжилгээний баг.

Мониторингид хамрагдсан Улаанбаатар хотын тойргуудад «Филантропи» Хөгжлийн төлөө төв ТББ-аар удирдуулсан 18 ажиглагч, судлаачдаас бүрдсэн баг, Өмнөговь аймгийн хоёр тойрогт Говийн Хөгжил ТББ-ын удирдсан иргэний нийгмийн байгууллагуудын төлөөллөөс бүрдсэн баг, Төв аймгийн 30-р тойрогт Энэрэнгүй Үйлс ТББ-аар удирдуулсан иргэний нийгмийн баг тус тус ажиллан ажиглалт хийж мэдээлэл цуглуулав. Мониторинг хэрэгжиж эхлэхээс өмнө орон нутгийн багийн гишүүдийг сургалтад хамруулан арга зүйг эзэмшүүлж, гарын авлагаар хангасан. Мониторингийн төслийн удирдагчаар «Филантропи» Хөгжлийн төлөө төв ТББ-ын хуульч З.Уянга ажиллалаа.



## ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ОРЧИН

Монгол Улсад сонгуулийн санхүүжилттэй холбоотой харилцааг 2015 оны 12 дугаар сарын 25-ны өдөр баталсан Сонгуулийн тухай хууль болон бусад холбогдох эрх зүйн актаар зохицуулж байна. Сонгуулийн тухай хуульд санхүүжилттэй холбоотой заасан гол асуудлуудыг дурдвал:

1. Сонгуульд оролцогч нам эвсэл, нэр дэвшигчид тусгайлан сонгуулийн зардлын данс нээлгэх, улмаар зөвхөн уг дансаар сонгуулийн кампанитай холбоотой гүйлгээг хийх, үүнийг зөрчвөл хүлээлгэх хариуцлагыг тодорхой болгосон.
2. Зөвшөөрөх, хориглох хандивын эх үүсвэр, хувь хүн болон хуулийн этгээдээс хүлээн авах хандивын дээд хэмжээг тогтоосон.
3. Эх үүсвэр нь тодорхойгүй хандивыг буцаах, зардлын данснаас гадуур бэлэн мөнгөөр хандив авч зарцуулахыг хориглосон.

4. Сонгуульд оролцогч нам эвсэл, нэр дэвшигчийн зардлын дансны тайланд хяналт тавих, ийнхүү хяналт тавьсан дүн болон хандивлагчдын нэрийг ил болгох үүргийг ҮАГ-т хүлээлгэсэн.

Сонгуулийн тухай хуульд зааснаар зардал нь дараах хөрөнгөөс бүрдэнэ. Үүнд:

1. Хандив
2. Намын өөрийн хөрөнгө
3. Нэр дэвшигчийн өөрийн хөрөнгө (40.2).

Сонгуулийн тухай хуулиас мониторингтой холбоотой гол зохицуулалтыг дэлгэрүүлж авч үзвэл:

## Сонгуулийн хандив

Шинээр батлагдсан Сонгуулийн тухай хуульд сонгуульд оролцогч мөнгөн ба мөнгөн бус хэлбэрээр хандив авах боломжтой гэж заасан нь өмнөх хуулиудаас ялгаатай байв. Мөнгөн бус хандивыг зөвхөн нэр дэвшигчид (51.2) гэрээ байгуулан өгөх (51.3) боломжтой ба үүнд:

1. Үл хөдлөх, хөдлөх эд хөрөнгийг үнэ төлбөргүй ашиглуулах, эзэмшүүлэх
2. Үнэ төлбөргүй үйлчилгээ тус тус багтана.

Мөнгөн бус хандивын үнэлгээг хандивын гэрээгээр харилцан тогтоох бөгөөд уг үнэлгээ нь иргэн болон хуулийн этгээдээс өгөх хандивын дээд хэмжээнээс хэтрэхгүй байна (51.4).

Иргэн нэг нам, эвсэл, нэр дэвшигчид жилд зөвхөн нэг удаа, дээд тал нь 3 сая хүртэлх төгрөгийн хандив өгч болох ба хуулийн этгээд бол 15 сая хүртэлх төгрөг хандивлаж болно. Түүнчлэн эвсэлд нэгдсэн намд сонгуульд зориулж хандив өгсөн бол тухайн намын нэгдсэн эвсэлд давхардуулан хандив өгөхийг хориглосон байна (50.3).

Хуулийн 40.6-д **хандивын бус аргаар** сонгуулийн зардал цуглуулах, бэлэн мөнгөөр авсан хандивыг зардлын дансанд оруулалгүй зарцуулахыг хориглоно гэжээ. Түүнчлэн нам, нэр дэвшигчийн аль аль нь зээлийн хөрөнгийг сонгуулийн сурталчилгаанд зарцуулахыг хориглосон байна (53.3 болон 54.4).

Хуульд зааснаар хандив өгөхийг хориглосон болон эрх зүйн байдал нь тодорхойгүй этгээд хандив өгсөн бол буцаах ёстой. Тухайлбал, хандив өгч байгаа иргэн, хуулийн этгээд нь регистрийн дугаараа банкны гүйлгээний баримтад заавал тусгах бөгөөд энэ шаардлагыг хангаагүй хандивыг хүлээн авагч буцаан шилжүүлнэ (50.4). Буцах хаяг нь тодорхойгүй хандивыг холбогдох хууль тогтоомжийн дагуу улсын орлого болгох буюу төрийн санд шилжүүлнэ гэж заажээ (50.5).

## Сонгуулийн зардлын данс

- А) *Намын зардлын данс*: Улс төрийн нам улсын хэмжээнд нэг зардлын данстай байхаас гадна аймаг, сум, дүүрэгт салбартай бол тухайн газраа зардлын данстай байхаар хуульчилжээ (43-р зүйл). Өмнө нь энэхүү дансыг сонгуулийн үеэр нээдэг байсан бол 2015 оны хуулиар намын зардлын дансыг байнгын болгосноороо онцлогтой. УИХ-ын сонгуулийн үеэр нам сонгуульд оролцохоор бүртгүүлсэн өдрөөс эхлэн зардлын тайлан хүргүүлэх өдрийг хүртэл дээрх данснаас зарлага гаргах ба бусад үед зарлага гаргахыг хориглосон байна. Гэвч орлого оруулахыг хэдийд ч зөвшөөрөхөөр зохицуулалт хийжээ.
- Б) *Эвслийн зардлын данс*: Эвсэл байгуулагдсан өдрөөсөө хойш тав хоногийн дотор улсын хэмжээнд нэг зардлын данс нээлгэх бөгөөд аймаг, нийслэлд мөн данстай байж болно (45-р зүйл). Данс нээлгэснээс хойш 3 хоногийн дотор дансны дугаар, банкны нэрийг холбогдох төрийн эрх бүхий байгууллагуудад мэдэгдэж бүртгүүлэх бөгөөд ээлжит сонгуулийн хугацаанд буюу эвсэл тарах хүртэл ашиглаж болно. Ээлжит сонгуулийн хугацааг дараагийн ээлжит сонгуулийн сурталчилгаа эхэлсэн өдрөөр дуусгавар болгоно гэж ойлгоно хэмээн хуульд тодотгосон байна. Түүнчлэн данснаас хуульд заасан хугацаанаас бусад үед зарлага гаргахыг хориглох боловч орлого оруулж болохоор хуульчилжээ. Эвсэлд нэгдсэн намуудын хувьд тус тусын зардлын данснаас эвслийн зардлын дансанд мөнгөн хөрөнгө шилжүүлэхээс өөрөөр тухайн ээлжит сонгуулийн хугацаанд буюу эвсэл тарах хүртэл бие даан зардал гаргахыг хориглоно.
- В) *Нэр дэвшигчийн зардлын данс*: УИХ-д нэр дэвшигчийн хувьд тухайн нэр дэвшигчийг сонгуульд оролцуулахаар бүртгэх тухай шийдвэр гарснаас хойш зардлын данс нээлгэн, улмаар 5 хоногийн дотор холбогдох төрийн байгууллагуудад мэдэгдэж бүртгүүлэхээр

хуулийн 47-р зүйлд зааж зохицуулжээ. Нэр дэвшигч уг дансандаа өөрийн хөрөнгө, хандивыг хуримтлуулах бөгөөд нам, эвслээс нэр дэвшсэн хүмүүсийн хувьд дээрхээс гадна нэр дэвшүүлсэн нам, эвслийн зардлын данснаас шилжүүлсэн мөнгөн хөрөнгийг хуримтлуулна гэж заажээ.

## **Сонгуулийн зардлын дээд хэмжээ ба зардлын зориулалт**

Хуулийн 41.1-д Төрийн аудитын дээд байгууллага нь тойрогт нэр дэвшигчээс сонгуульд зарцуулах зардлын дээд хэмжээг уг тойргийн нутаг дэвсгэрийн хэмжээ, байршил, хүн амын тоо зэргийг харгалзан тогтооно гэж заасан байх ба нам, эвслийн хувьд мөн ижил хугацаанд зардлын дээд хэмжээг тогтоох (41.2) боловч ямар шалгуурт үндэслэж хэрхэн тогтоох тухай тодорхой заагаагүй орхижээ.

Зардлын зориулалтын хувьд

- Мөрийн хөтөлбөр тайлбарлан таниулах
- Нам, эвсэл, нэр дэвшигчийг сурталчлах
- Уулзалт, хурал, цуглаан зохион байгуулах
- Бичиг хэрэг, шуудан холбоо, унааны болон томилолт, хөлс урамшуулал
- Дээр дурдсан зардалтай холбоотой бусад зардалд зарцуулж болно гэж зохицуулсан.

## **Сонгуулийн зардлыг бууруулахад чиглэсэн зохицуулалтууд**

Шинэ хуулийн 68.1-д зааснаар сонгуулийн сурталчилгааг санал авах өдрөөс 18 хоногийн өмнө эхлүүлж, нэг хоногийн өмнө дуусгах ба нийт 17 хоног буюу харьцангуй богино байгааг зарим судлаачид шүүмжилдэг.

Сонгогчдын саналыг янз бүрийн хэлбэрээр худалдан авах байдал газар авч байсныг 2007 оноос хойш хуулиар хориглох болсон ба сонгуулийн жил эхэлснээс хойш санал хурааж дуустал аливаа этгээд сонгогчдын саналыг татах зорилгоор мөнгө, эд зүйл тараах,

уралдаан, тэмцээн, баяр наадам, урлагийн тоглолт, хүлээн авалт зохион байгуулах гэх мэт үйлдэл хийхийг хориглосон (68.1). Түүнчлэн сонгогчдын саналыг татах зорилгоор бусдаар дамжуулан, эсхүл хүмүүнлэгийн, буяны, шашны байгууллага болон төрийн бус байгууллага, сангийн нэрээр халхавчлан сонгогч, түүний гэр бүлийн гишүүн, насанд хүрээгүй хүн, байгууллага, хамт олонд үнэ төлбөргүй эд бараа тараах, хөнгөлөлттэй үнээр худалдах, цалин хөлс, урамшуулал, тэтгэлэг олгох, эдийн болон эдийн бус давуу байдал олгох, амлах, сонгогчдын санал худалдан авахад чиглэсэн бусад аливаа үйлдэл, үйл ажиллагаа явуулахыг хориглодог.

Сонгуулийн зардлыг бууруулахтай холбоотойгоор сонгуулийн сурталчилгаанд ашиглах хэвлэмэл материал, зурагт самбар зэргийн хэмжээг хязгаартай байхаар зохицуулснаас гадна сонгуулийн хэсэг бүрт ажиллуулах ухуулах байрны тоог хоёроос илүүгүй байна гэж тогтоожээ. Түүнчлэн энэ сонгуулиар анх удаа бизнесийн зорилгоор байнга ашиглагддаг сурталчилгааны самбар, түүний орон зайг сонгуулийн сурталчилгааны зурагт самбарын зориулалтаар ашиглахгүй байхаар хуульчилсан.

Зардал хамгийн их шаарддаг сурталчилгааны арга хэрэгсэл болох радио, телевизийн сурталчилгааны хувьд «хаалтын гэрээ» гэж хэлж заншсан гэрээ байгуулахыг хуулийн 70.7-р заалтаар хориглосон. Мөн сурталчилгааны төлбөрт нэвтрүүлгийн нийт хугацаа нь хоногт нэг цаг (60 минут)-аас илүүгүй байна. Сурталчилгааны нэвтрүүлгийн төлбөр нь тухайн радио, телевиз сурталчилгааны сүүлийн зургаан сарын дундаж төлбөрийн хэмжээнээс хэтрэхгүй байна гэж зохицуулжээ (82.7).

## **Төрийн эх үүсвэрийг ашиглахтай холбоотой зохицуулалт**

Сонгуулийн үйл ажиллагаанд төрийн байгууллагад ажилладаг улс төрийн албан хаагчаас бусад албан хаагчийг дайчлан оролцуулахыг хуулиар хориглохоос гадна хуульд зааснаас бусад тохиолдолд төрийн болон нутгийн өөрөө удирдах байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн тээврийн хэрэгсэл, бусад өмч хөрөнгийг аливаа хэлбэрээр сонгуулийн сурталчилгаанд ашиглахыг хориглоно.

## Сонгуулийн санхүүжилтийн тайлагналт, хяналт

Сонгуулийн өдрөөс өмнө:

Нам, эвсэл, нэр дэвшигч сонгуульд оролцохоор бүртгүүлэхдээ СЕХ-нд дараах мэдээллийг бүрдүүлэн өгөх ёстой.

*Нам эвсэл:*

- сонгуулийн зардлын дансны талаарх мэдээлэл
- сүүлийн нэг жилийн хугацаанд тухайн намд иргэн, хуулийн этгээдээс өгсөн хандивыг төрийн аудитын байгууллагаар хянуулж баталгаажуулсан тайлан (121.3.6-7)

*Нэр дэвшигч:*

- нэр дэвшигчийн хөрөнгө, орлогын мэдүүлэг
- нэр дэвшигчийн хуульд заасан өр төлбөргүйг нотолсон татварын болон шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын тодорхойлолт (128.2.4, 5). Үүнд:
  - банк, бусад хуулийн этгээд, иргэнд шүүхийн шийдвэрээр тогтоогдсон төлбөл зохих зээл, барьцаа, батлан даалтын өргүй байх
  - албан татварын хугацаа хэтэрсэн өр төлбөргүй байх
  - нэр дэвшигч нь аль нэг компанийн 51 ба түүнээс дээш хувьцааг эзэмшдэг бол тухайн компани нь албан татварын хугацаа хэтэрсэн өр төлбөргүй байх ёстой.

Сонгуулийн дараа:

*Нэр дэвшигч:* Санал хураалт явагдсан өдрөөс хойш 30 хоногт багтаан сонгуулийн зардлын тайлан гаргаж СЕХ-нд хүргүүлнэ (58.1). Ингэхдээ тайландаа аудит хийлгэж, дүгнэлт гаргуулсан байна. Зардлын тайланг дараах үзүүлэлтээр гаргана.

- сонгуулийн зардлын дансанд орсон орлогын нийт хэмжээ. Үүнд:
  - а. өөрийн хөрөнгөөс оруулсан орлого
  - б. нам, хамтарсан намууд, эвслээс оруулсан орлого
  - в. хандивын орлого
- хандивлагч иргэний эцэг (эх)-ийн нэр, өөрийн нэр, оршин суугаа газрын хаяг, хандивын хэмжээ, хэлбэр



- хандивлагч хуулийн этгээдийн нэр, оршин байгаа газрын хаяг, гүйцэтгэх захирлын эцэг (эх)-ийн нэр, өөрийн нэр, хандивын хэмжээ, хэлбэр
- зарлагын ангилал, гүйцэтгэл
- үлдэгдлийн хэмжээ, байршил.

Түүнчлэн, нэр дэвшигчийн сонгуулийн зардлын данс байршуулсан банкны захирал, салбарын эрхлэгч нь уг дансны бүх гүйлгээг нэгтгэн тайлан гаргаж, санал хураалт дууссан өдрөөс хойш 30 хоногийн дотор СЕХ-нд хүргүүлэх ёстой.

*Нам, эвсэл:* Нам, эвсэл нь санал хураалт явагдсан өдрөөс хойш 45 хоногт багтаан зардлын тайлангаа гаргаж сонгуулийн төв байгууллагад хүргүүлнэ. Энэхүү зардлын тайлан нь мөнгөн ба мөнгөн бус хөрөнгийнх байна (57.1-3). Тайландаа мөн дээрхийн адил аудит хийлгэж дүгнэлт гаргуулсан байх ба дараах үзүүлэлтээр гаргана:

- сонгуулийн зардлын данснаас зарлага гаргаж эхлэхийн өмнөх мөнгөн хөрөнгийн хэмжээ, эх үүсвэр (гүйлгээ тус бүрээр)
- сонгуулийн зардлын дансны зарлагын гүйлгээ нээсэн өдрөөс хаагдах өдөр хүртэлх хугацаанд орсон орлогын хэмжээ
- сонгуулийн зардлын дансны зарлагын гүйлгээ нээсэн өдрөөс хойш хаагдах өдөр хүртэлх хугацаанд орсон орлогын эх үүсвэр (гүйлгээ тус бүрээр)
- зарлагын ангилал, гүйцэтгэл, гэрээний хамт
- үлдэгдлийн хэмжээ, байршил (нам, эвслийн буюу хэд хэдэн зардлын данстай бол данс тус бүрийн).

Нам, эвслийн сонгуулийн зардлын данс байршуулсан банкны захирал, эсхүл салбарын эрхлэгч нь уг дансны бүх гүйлгээг нэгтгэсэн тайлан гаргаж, санал хураалт дууссан өдрөөс хойш сонгуулийн төв байгууллагад 45 хоногийн дотор хүргүүлнэ (57.6).

Хуульд заасан хугацаанд тайлангаа ирүүлэхгүй бол тухайн нам, эвсэл, нэр дэвшигчийг дараагийн сонгуульд бүртгэхгүй байхаар хуульчилсан байна.

## Сонгуулийн санхүүжилтийн ил тод байдлыг зохицуулсан байдал

Манай Улсад Сонгуулийн санхүүжилтийн ил тод байдлыг дараах хууль тогтоомжоор зохицуулсан байдаг. Үүнд:

Авлигын эсрэг Нэгдсэн Үндэстний Байгууллагын конвенц

Энэхүү конвенцийг Монгол Улс 2005 онд соёрхон баталж, түүнд нэгдэн орсон бөгөөд конвенцийн 7.3-д «Оролцогч улс бүр сонгогддог нийтийн албан тушаалд нэр дэвшүүлэх үйл ажиллагааны санхүүжилт болон холбогдох тохиолдолд улс төрийн намын санхүүжилтийн ил тод байдлыг дээшлүүлэх зорилгоор хууль тогтоох болон захиргааны зохих арга хэмжээг энэхүү конвенцийн зорилт болон дотоод хууль тогтоомжийнхоо тулгуур зарчимд нийцүүлэн авах асуудлыг мөн авч үзнэ» гэж заажээ.

– Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль

УИХ-ын чуулганы 2011 оны 6 дугаар сарын 16-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль батлагдсанаар төрийн байгууллагуудад мэдээллээ нээлттэй байлгах үүрэг ногдуулж иргэн, хуулийн этгээд төрийн байгууллагаас мэдээлэл авах эрхийг баталгаажуулсан юм. Энэ хуулийг 2011 оны 12 дугаар сарын 1-ний өдрөөс дагаж мөрдөж эхэлсэн билээ.

– Сонгуулийн тухай хууль

*5 дугаар зүйл «Сонгуулийн үйл ажиллагааг зохион байгуулахад баримтлах зарчим»*

Сонгууль зохион байгуулах төрийн болон нутгийн өөрөө удирдах байгууллага, түүний албан тушаалтан, нэр дэвшигч, сонгуульд оролцогч нам, эвсэл, бусад байгууллага, түүний албан тушаалтан сонгуулийн үйл явцыг зохион байгуулах, түүнд оролцохдоо **ил тод байдлыг хангах** (5.1.2) зарчмыг баримтална.

*60-р зүйл «Сонгуулийн зардлын тайлангийн хяналт ба нээлттэй ил тод байдал»*

Нам, эвсэл, нэр дэвшигчдийн зардлын дансны тайланг СЕХ хүлээн авч төрийн аудитын дээд байгууллагад шилжүүлэх бөгөөд нэг хувь олшруулан татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ. Төрийн аудитын

байгууллага тайланг хянах ба хүлээн авсан өдрөөс хойш 90 хоногийн дотор дүнг нийтэд мэдээлнэ. Түүнчлэн 1 сая болон түүнээс дээш хандив өгсөн иргэн, 2 сая болон түүнээс дээш төгрөгийн хандив өгсөн хуулийн этгээдийг зарлана гэж хуульчилжээ.




## МОНИТОРИНГИЙН ДҮН

### Сонгуулийн зардлын ерөнхий дүр зураг

2016 оны оны УИХ-ын сонгуульд нийт 12 нам, 3 эвсэл, 498 нэр дэвшигч оролцсон бөгөөд УАГ-аас гаргасан сонгуулийн зардлын тайланг хянасан аудитын дүнд дурдсанаар сонгуульд оролцсон 11 нам, 2 эвсэл нийт 8,363.9 сая төгрөг төвлөрүүлснээс 8,349.3 саяыг нь зарцуулжээ. Харин 498 нэр дэвшигчээс 386 нь сонгуулийн зардлын тайлангаа хуульд заасны дагуу холбогдох төрийн байгууллагуудад ирүүлсэн нь нийтдээ 26,010,9 сая төгрөг болжээ. Эндээс харахад нам, эвсэл, нэр дэвшигчдийн зардлын нийлбэр дүн 34 тэрбум 360.2 сая төгрөг болж байна. 2016 оны УИХ-ын сонгуулийн нэрийн жагсаалтад нийт 1,911,047 сонгогч бүртгэгдсэн байсан. Дээрх зардлыг үндэслэн нэг сонгогчид ногдох сонгуулийн кампанит ажлын зардлыг өмнөх сонгуулиудтай харьцуулан графикаар харуулав.

### Нэг сонгогчид ногдох кампанит ажлын зардал (төгрөгөөр)



Түүнчлэн нэр дэвшигч болон намуудын кампанит ажлын нийт зардлыг тухайн жилийн ДНБ-тэй харьцуулан доорх хүснэгтэд харуулав.

### Кампанит ажлын зардал ба ДНБ

Сонгуулийн жил (УИХ)	Нэр дэвшигч болон намуудын кампанит ажлын нийт зардал (сая төгрөгөөр)	Нэг хүнд ногдох ДНБ (тухайн жилд), (мянган төгрөгөөр)
1992	13.7	25.9
1996	209.3	326.6
2000	1,841.8	490.6
2004	1,558.4	858.0
2008	7,978.3	2,480.2
2012	36,863.0	5,876.8
2016	34,360.2	7,642.9 <sup>1</sup>

Дээрх графикаас харахад 2012 оны УИХ-ын сонгуулиар нэг сонгогчид ногдох сонгуулийн зардал хамгийн өндөр байсан бол 2016 онд харьцангуй буурсан мэт харагдана.

2012 оны сонгууль нь холимог тогтолцоогоор явагдсан ба 11 нам, эвсэл, 544 нэр дэвшигч сонгуульд өрсөлдсөнөөс 190 нь намын жагсаалтаар нэр дэвшиж байжээ. Тухайн жилийн статистикийн тайлан мэдээллээс нэг ажилтанд оногдож байсан улсын дундаж цалинг харьцуулж үзвэл 2012 онд 557.6 мян. төгрөг байсан бол 2016 оны 3 дугаар улирлын байдлаар 884.3 мян. төгрөг байв.<sup>1</sup> 2012 онтой харьцуулахад 2016 онд эдийн засгийн өсөлт нэлээд буурсан ч инфляцийн түвшин харьцангуй бага байсныг харгалзвал сонгуулийн зардлыг бууруулахад чиглэсэн арга хэмжээ зарим талаар үр дүнгээ өгч байгаа мэт харагдаж байна. Гэсэн хэдий ч дээрх дүгнэлт нь сонгуульд оролцсон нам, эвсэл, нэр дэвшигчдийн төрийн аудитын байгууллагад хүлээлгэн өгсөн албан ёсны тайланд үндэслэсэн бөгөөд тайлангийн чанараар баталгаажих учиртайг санахад илүүдэхгүй.

Зардлын тайлангийн чанарт үнэлгээ хийх нөхцөлийг хангахад сонгуулийн зардлын мэдээлэл ил тод байх нь чухал юм. **Бодит байдалд сонгуулийн санхүүжилтийн мэдээлэл ил тод бус, түүнд тавих хяналт туйлын хангалтгүй байв.** Үүнд төрийн аудит болон холбогдох байгууллагуудад хүлээлгэн өгч буй нам, эвсэл, нэр дэвшигчдийн тайлан бүрэн гүйцэд байхаас гадна тэдгээрийг ил тод болгох, сонгуулийн кампанит ажлын явцад сонгуульд хяналт тавьж буй бие даасан ажиглагчид, иргэний нийгмийн байгууллагууд зардалтай холбоотой мэдээлэл олж авах, албан ёсны дүнтэй тулган хянах боломжтой байх ёстой. Уг мониторингийг чухамхүү ийм зорилгын хүрээнд хэрэгжүүлсэн бөгөөд бодит байдалд сонгуулийн санхүүжилтийн мэдээлэл огт ил тод бус, түүнд тавих хяналт туйлын хангалтгүй байгаа нь харагдлаа.

<sup>1</sup> Монгол Улсын Үндэсний Статистикийн Хороо, Монгол Улсын нийгэм, эдийн засгийн байдал (2016 оны эхний 11 сарын байдлаар) <<http://www.nso.mn/content/1448#.WGIVY9J94dU>> сүүлд нэвтэрсэн огноо 2016 оны 12 дугаар сарын 27

*Сонгуулийн тухай хуульд сонгуулийн зардлыг бууруулж, тэгш өрсөлдөөний нөхцөл бүрдүүлэх зорилготой хэд хэдэн зохицуулалт тусгагдсан бөгөөд үүнд төрийн үнэ төлбөргүй дэмжлэг, зарим зардлыг хязгаарласан зохицуулалтууд багтаж байна.*

### **Төрийн санхүүжилт/дэмжлэг**

1. Олон нийтийн радио, телевиз нь сурталчилгааны нэвтрүүлгийг сонгуулийн төв байгууллагаас сонгуульд оролцогч нам, эвсэл, түүнчлэн Ерөнхийлөгчийн сонгуульд нэр дэвшигч тус бүрээр тогтоосон хуваарь, цагийн дагуу зөвхөн үнэ төлбөргүй нэвтрүүлнэ.
2. Түүнчлэн
  - Төрийн болон нутгийн өөрөө удирдах байгууллага
  - Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд
  - Төрийн болон орон нутгийн өмчийн 51 хувь ба түүнээс дээш оролцоотой хуулийн этгээд сонгуулийн уулзалт, хурал, цуглаан хийхэд зориулж өөрийн эзэмшиж байгаа соёлын төв, биеийн тамирын, хурлын болон бусад байр, танхимыг гаргаж өгөх, үнэ төлбөргүйгээр ашиглуулах үүрэгтэй.
3. Зурагт болон ухуулах хуудсыг сонгогчдод тараахаас гадна дараах газар үнэ төлбөргүй байрлуулж болно:
  - зориулалтын зарлалын самбар
  - нийтийн эзэмшлийн хашаа, хайс, гэрлийн шон.

Зурагт болон ухуулах хуудсыг гудамж, талбай, олон нийтийн газарт байрлуулах байршлыг нам, эвсэл, нэр дэвшигчийн эрх тэгш байдлыг хангах зарчмыг баримтлан сонгуулийн жилийн дөрөвдүгээр сарын нэгний дотор тухайн сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчид тогтооно (77.8).

---

Монгол Улсын Үндэсний Статистикийн Хороо, Монгол Улсын Статистикийн эмхэтгэл-2012, 124-р хуудас

## Мониторингид хамрагдсан 7 тойргийн нэр дэвшигчдийн сонгуулийн санхүүжилтийн мэдээлэл

Сонгуулийн санхүүжилтийн мониторингид хамрагдсан Баянзүрх дүүргийн 49, 53; Сүхбаатар дүүргийн 60, 61; Төв аймгийн 30; Өмнөговь аймгийн 22 болон 23 дугаар тойргуудад нийт 50 нэр дэвшигч өрсөлдсөнөөс 23 нэр дэвшигчийн зардлын тайлангийн дэлгэрэнгүй мэдээллийг авах боломж олдсон. Тэдний зардлын дансанд төвлөрүүлсэн нийт хөрөнгө нь 1,5 орчим тэрбум гаруй төгрөг болжээ. Үүнийг эх үүсвэрээр нь задалж дараах хүснэгтэд харуулав.

### Мониторингид хамрагдсан нэр дэвшигчдийн зардлын дансанд төвлөрсөн хөрөнгө

Эх үүсвэр	Дүн (төгрөгөөр)
Хуулийн этгээдээс	321,124,200
Иргэдээс	672,451,100
Намын хөрөнгө	82,020,000
Нэр дэвшигчийн өөрийн хөрөнгө	363,150,300
<b>Нийт</b>	<b>1,438,745,600</b>

Мониторингийн хүрээнд дэлгэрэнгүй мэдээлэл авсан 23 нэр дэвшигчийн сонгуулийн зорилгоор хуримтлуулсан хөрөнгийн 70 гаруй хувь нь иргэдийн хандив болон өөрийн хөрөнгөөс бүрджээ. Харин нам болон хуулийн этгээдээс өгсөн хандив 28 хувийг эзэлж байна.

### Санхүүжилтийн эх үүсвэр (хувиар)






Гаргасан нийт зардлыг нэр дэвшигчдийн нам, эвслийн харьяаллаар нь задалж доорх хүснэгтэд харуулав:

**Мониторингид хамрагдсан нэр дэвшигчдийн  
гаргасан зардал, намын харьяаллаар**

Нам ба бие даан нэр дэвшигчид	Нийт зардал (төгрөгөөр)
Ардчилсан нам	586,875,200
Монгол ардын нам	579,395,400
Монгол ардын хувьсгалт нам	57,251,800
Тусгаар тогтнол, эв нэгдлийн нам	29,523,900
Иргэний зориг ногоон нам	14,088,500
Бүгд найрамдах нам	12,712,400
Иргэний хөдөлгөөний нам	2,999,100
Социал демократ нам	1,185,600
Бие даан нэр дэвшигч	37,179,800
<b>Нийт</b>	<b>1,321,211.70</b>

Үүнийг графикаар харуулбал:



Ажиглалт хийсэн багийн зүгээс нийт 7 тойрогт сонгуулийн санхүүжилтэд нарийвчилсан мониторинг хийхдээ УИХ дахь суудлынхаа тоонд үндэслэн төсвөөс санхүүжилт авдаг гурван нам, тэдгээрээс нэр дэвшиж өрсөлдсөн хүмүүсийн мэдээлэлд анхаарал хандуулсан. Ингэхдээ сонгуулийн сурталчилгаа, зардалтай холбоотой дараах асуудлуудыг 3 үе шаттайгаар судалж авч үзэв. Үүнд:

Сонгуулийн кампанит ажлын өмнө:

- Намуудын хандивын тайлан
- Нэр дэвшигчдийн хөрөнгө орлогын мэдүүлгийн ил тод байдал

Сонгуулийн кампанит ажлын үеэр:

- Хуулиар хориглосон арга хэлбэрээр сурталчилгаа явуулж буй эсэх
- Хуулиар зөвшөөрсөн хэлбэрээр үйл ажиллагаа явуулахдаа тогтоосон хязгаарыг мөрдөж буй эсэх, кампанит ажлын явц дахь мэдээллийн ил тод байдал. Үүнд:
  - Штабын шадар туслагч, ухуулагчийн тоо, тэдэнд өгч буй урамшууллын хэмжээ
  - Тээврийн хэрэгсэл, ухуулах байрны тоо, түрээсийн үнэ
  - Зурагт самбар болон сонгогчдод түгээж буй бусад сурталчилгааны материалын тоо, үнэ зэрэг асуудлаар мэдээлэл цуглуулж ажиглалт хийх.

Сонгуулийн дараа:

- Зардлын тайлангийн ил тод байдал, түүнд төрийн холбогдох байгууллагуудын зүгээс тавьж буй хяналт ямар түвшинд байгааг үнэлэх.

Дээрх үе шатаар хийсэн мониторингийн дүнгээс харахад сонгуулийн санхүүжилтийн мэдээлэл сонгууль болох өдрөөс өмнө болон сонгуулийн кампанит ажлын үеэр нууцлагдмал байна. Түүнчлэн сонгуулийн дараа нам, эвсэл, нэр дэвшигчдийн зүгээс гаргаж байгаа зардлын тайлан иж бүрэн бус байгаа нь үр дүнтэй хяналт тавихад саад учруулж байна.

Мониторингийн үр дүнг 1) сонгуулийн өмнөх үе, 2) сонгуулийн кампанит ажлын үе болон 3) санал хураалт явагдсан өдрөөс хойших үе гэж задлан авч үзвэл:

## **1. Сонгуулиас өмнө нам, эвсэл, нэр дэвшигчдийн сонгуулийн санхүүжилтийн мэдээлэл олон нийтэд хаалттай хэвээр байна**

2015 онд баталсан Сонгуулийн тухай хуульд сонгуулийн санхүүжилтийн ил тод байдлыг нэмэгдүүлэхэд чиглэсэн чухал заалтууд шинээр тусгалаа олсон нь сонгуулийн өмнө буюу нам, эвсэл, нэр дэвшигчид сонгуульд оролцохоор бүртгүүлэхдээ санхүүжилтийн мэдээллээ тайлагнаж ил болгохыг шаардсан зохицуулалтууд юм. Үүнээс өмнө сонгуульд өрсөлдөж буй талуудын санхүүжилтийн тайланг сонгууль өнгөрснөөс хойш сар гаруйн дараа л бүрэн биш байдлаар авах бололцоотой байв.

Хуульд дээр дурдсан шинэ зохицуулалтууд нэмэгдсэнээр:

*Нам эвсэл сонгуульд оролцохоор бүртгүүлэхдээ:*

- сонгуулийн зардлын дансны талаарх мэдээлэл
- сүүлийн нэг жилийн хугацаанд тухайн намд иргэн, хуулийн этгээдээс өгсөн хандивын төрийн аудитын байгууллагаар хянуулж баталгаажуулсан тайлан (121.3.6-7).

*Нэр дэвшигч бүртгүүлэх хүсэлт гаргахдаа:*

- хөрөнгө, орлогын мэдүүлгээ сүүлийн бүтэн жилийн байдлаар гаргаж өгөх ёстой (157.2.4).

Монгол Улсад хүчин төгөлдөр үйлчилж буй холбогдох хууль тогтоомжийн хүрээнд дээрх мэдээлэл олон нийтэд нээлттэй, ил тод байх учиртай. Гэвч мониторингийн явцад дээрх мэдээлэл бүгд хаалттай байгаа нь ажиглагдсан юм. Өөрөөр хэлбэл хууль огт хэрэгжихгүй байна. Тухайлбал, хөрөнгө орлогын мэдүүлэг нь «олон нийтэд нээлттэй байна» гэж Авлигын эсрэг хуульд маш тодорхой зааж тусгасан.

*Авлигын эсрэг хууль*

### **14 дүгээр зүйл. Хөрөнгө, орлогын мэдүүлгийг нийтэд мэдээлэх**

14.2. Энэ хуулийн 14.1-д зааснаас бусад этгээдийн хөрөнгө, орлогын мэдүүлэг **олон нийтэд нээлттэй** байна.

14.3. Энэ хуулийн 4.1-д заасан этгээдийн хөрөнгө, орлогын сүүлийн 5 жилийн мэдүүлэг Авлигатай тэмцэх газрын цахим мэдээллийн сүлжээнд тавигдах ба иргэд мэдээлэл авах боломжийг хангана.

14.4. Иргэд бичгээр, амаар, цахим мэдээллийн сүлжээгээр дамжуулан мэдээлэл авч болох бөгөөд тэдгээрт мэдээлэл өгөх журмыг Авлигатай тэмцэх газар батална.

Тодруулбал, Авлигын эсрэг хуулийн 4.1.6-д тус хуулийн үйлчлэлд хамаарах этгээдэд «Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурал, бүх шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд нэр дэвшигч багтана» гэсэн байгаа бол хуулийн 11.2-т бүх шатны сонгуульд нэр дэвшигчдийн хөрөнгө орлогын мэдүүлгийг СЕХ хүлээн авч сонгууль дуустал хадгалах ба «сонгуулийн нэгдсэн дүн гарсны дараа тухайн сонгуульд сонгогдогчийн хөрөнгө, орлогын мэдүүлгийг санал хураалт дууссанаас хойш 14 хоногийн дотор Авлигатай тэмцэх газарт ирүүлж, хадгалуулна» (11.4) гэжээ.

Төслийн баг Авлигын эсрэг хуулийн 14.2-т «хөрөнгө, орлогын мэдүүлэг олон нийтэд нээлттэй байна» гэж заасныг үндэслэн мониторингид хамрагдсан тойргуудад нэр дэвшсэн хүмүүсийн хөрөнгө, орлогын мэдүүлгийн мэдээллийг авах хүсэлтээ СЕХ-нд тавьсан. СЕХ-ны зүгээс 2016 оны 6 дугаар сарын 12-ны өдрийн 136 тоот албан бичгээр хариу өгсөн бөгөөд мэдээлэл өгөхөөс татгалзсан юм (Хавсралт 1-ийн А-г харна уу.). Татгалзсан үндэслэлээ тайлбарлахдаа «АТГ-ын 2012 оны 196 тоот тушаалаар баталсан «Албан тушаалтны хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгийн талаар мэдээлэх, мэдээлэл өгөх журам»-д сонгуульд нэр дэвшигчийн хөрөнгө, орлогын мэдүүлгийг нийтэд мэдээлэх, мэдээлэл өгөх тухай тусгагдаагүй байна» гэж тайлбарлажээ.

Энэхүү тайлбарт дурдсан журмын 3.1-д «Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага (цаашид «мэдээлэл хүсэгч» гэх)-аас гаргасан хүсэлтийн дагуу албан тушаалтны мэдүүлэг, мэдэгдэл, тайлбарын талаар түүнийг бүртгэж, хадгалж, хяналт тавьж буй байгууллагын удирдлагын зөвшөөрлөөр эрх бүхий албан тушаалтан мэдээлэл өгнө» гэж зохицуулсан байх агаад өөрөөр хэлбэл, уг журмыг дагавал сонгуульд нэр дэвшигчдийн хөрөнгө орлогын мэдүүлгийг СЕХ-ны даргын зөвшөөрлөөр эрх бүхий албан тушаалтан нь гаргаж өгөх үүрэгтэй байна. Энэ талаар АТГ-аас өгсөн хариу тайлбарыг хавсралтаас харна уу (Хавсралт 1-ийн Г).

Мониторингийн багийн зүгээс УИХ-ын сонгуульд оролцохоор бүртгүүлсэн нам, эвслийн сүүлийн нэг жилийн хугацаанд иргэн, хуулийн этгээдээс хүлээн авсан хандивыг төрийн аудитын байгууллагаар хянуулж баталгаажуулсан тайланг авах хүсэлтийг мөн СЕХ-нд хандаж гаргасан. Харин СЕХ-ноос дээрх мэдээллийг өгөхөөс мөн татгалзсан хариу ирүүлсэн ба ингэхдээ Төрийн аудитын байгууллага болон нам, эвсэлд хандаж авна уу? гэж зааварласан байлаа.

Сонгуулийн тухай хуульд нам, эвслийн сүүлийн нэг жилийн хугацаанд хүлээж авсан хандивын талаарх тайланд хэн, ямар хяналт тавих, ямар хугацаанд ил тод болгох талаар зааж тусгаагүй орхигдуулжээ. Гэвч Мэдээллийн ил тод байдал, мэдээлэл авах эрхийн тухай хуульд зааснаар иргэн, хуулийн этгээд нь хүний эрх, эрх чөлөө, үндэсний аюулгүй байдал, байгууллагын хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах зорилгоор хууль тогтоомжид нийтэд мэдээлэхийг хориглосноос бусад төрийн байгууллагын эзэмшилд байгаа бүх төрлийн мэдээ, баримт бичиг, гэрээ, контракттай холбоотой мэдээллийг авах эрхтэй (11.1) төдийгүй хуулийн 11.2-т зааснаар мэдээлэл авах тухай иргэн, хуулийн этгээдийн хүсэлтийг хүлээн авч байгаа төрийн байгууллагын холбогдох албан тушаалтан иргэнд энэ хуульд зааснаас бусад шаардлага тавих хориотой юм. СЕХ нь энэхүү хуулийн үйлчлэлийн хүрээнд хамаарах төсвөөс санхүүждэг байгууллага мөн болох тул өөрийн эзэмшилд байгаа мэдээллийг хуулийн дагуу хүсэлт гаргасан иргэний нийгмийн байгууллагад өгөөгүй нь мөн хууль зөрчсөн үйлдэл боллоо гэж дүгнэхэд хүрч байна. Дээрх мэдээллийг авахаар ҮАГ-т мөн хүсэлт гаргахад мэдээлэл өгөхөөс цааргалсан хариу өгсөн болно.

Эцэст нь дүгнэж хэлэхэд сонгуулийн тухай хуульд сонгуулиас өмнө нам, эвсэл, нэр дэвшигчдийн санхүүжилттэй холбоотой мэдээллийг ил болгохтой холбоотой мөрдөж ирсэн хуулиудтай харьцуулахад дэвшилттэй заалтууд туссан хэдий ч эдгээр нь хэрэгжихгүй байна. Сонгогчдын хувьд төдийгүй Сонгуулийн тухай хуулийн 5.5-д заасны дагуу сонгуулийн үйл явцад бие даасан мониторинг хийж буй иргэний нийгмийн байгууллагуудын хувьд дээрх мэдээлэл ил тод бус хаалттай байв. Холбогдох төрийн байгууллагуудын зүгээс мэдээлэл ил болгохоос болгоомжилсон хандлага гаргаж хуулиар хүлээсэн үүргээ гүйцэтгэхээс цааргалж байгаа нь үүнд нөлөөлж байна.

## **2. Сонгуулийн кампанит ажлын үеэр сонгуулийн зардал, санхүүжилттэй холбоотой мэдээлэл хамгийн хаалттай**

Сонгуулийн тухай хуульд сонгуулийн кампанит ажил эхлэхээс өмнөх болон сонгууль дууссаны дараа нам, эвсэл, нэр дэвшигчид санхүүжилтийн мэдээллээ хэрхэн тайлагнах талаар тусгаж зохицуулсан хэдий ч сонгогчдод хамгийн их мэдээлэл хэрэгтэй болдог сонгуулийн кампанит ажлын үеэр дээрх мэдээллийг хэрхэн ил тод болгох талаар зохицуулалт огт байхгүй байна. Эл бэрхшээлээс үл хамааран мониторингийн багийн зүгээс сонгосон тойргуудад

ажиглалт хийж мэдээлэл цуглуулахыг зорьсон ба энэхүү мэдээллээ санал хураалт явагдсан өдрөөс хойш нам, эвсэл, нэр дэвшигчдийн аудитаар хянуулсан тайлантай харьцуулж шинжлэх зорилгоор цуглуулсан юм.

Энэ хүрээнд сонгуулийн сурталчилгаатай холбоотой дараах асуудлуудыг анхааран ажиглалт хийв:

- Төрийн эх үүсвэрийг сонгуулийн сурталчилгаанд ашиглах, сонгогчдын санал худалдан авах зэрэг хууль зөрчсөн үйлдлүүд гарч буй эсэх;
- Сонгуулийн зорилгоор хуримтлуулсан хөрөнгийг хуулиар зөвшөөрсөн зориулалтаар, төрийн аудитын байгууллагаас тогтоосон хязгаарын хүрээнд зарцуулж буй байдал болон үйл ажиллагааны зардлын мэдээлэл.

Сонгуулийн кампанит ажлын хугацаанд буюу 2016 оны 6 дугаар сарын 11-ээс 6 дугаар сарын 27 хүртэл мониторингийн багийн ажиглагчид 150 удаагийн арга хэмжээ буюу уулзалт, хурал, цуглааныг ажиглаж хянасан ба ингэхэд төрийн эх үүсвэрийг сонгуульд ашиглаж байгаа болон сонгогчдын санал худалдан авах зорилгоор мөнгө, эд зүйл тараасан ноцтой зөрчил илрээгүй. Гэвч зарим нэг тойрогт уулзалт, хурал, цуглааныг олны танил жүжигчдээр хөтлүүлэх, оролцсон сонгогчдыг үнэ өртөг багатай цай идээгээр дайлах, хувьцааны анкет бөглүүлж авах зэрэг цөөн тооны үйлдэл ажиглагджээ. Гэхдээ энэ нь зөвхөн мониторингид хамрагдсан 7 тойргийн хэмжээнд сонгуульд өрсөлдсөн УИХ-д суудалтай 3 намаас нэр дэвшсэн 21 нэр дэвшигчийн штабаас албан ёсоор зохион байгуулсан арга хэмжээнд оролцож ажиглалт хийсэн үр дүн юм.

Мониторингийн багийн зүгээс Цагдаагийн Ерөнхий Газарт удаа дараа хандан хүсэлт тавьсны эцэст хүлээн авсан улсын хэмжээний мэдээллээс харвал (Хавсралт 1-ийн Б-г харна уу.). 2016 оны ээлжит сонгуулийн үеэр иргэд байгууллагаас сонгуулийн үйл ажиллагаатай холбоотой нийт 1399 гомдол, мэдээллийг цагдаагийн байгууллагад ирүүлснийг бүртгэн шалгасан аж. Эдгээрийн 158 нь буюу 11,9 хувь нь Сонгуулийн тухай хуулийн 70 дугаар зүйлийн 70.1.1, 70.1.3, 70.1.5 дахь заалтыг зөрчсөн гэх гомдол мэдээлэл байсан байна. Цагдаагийн байгууллагад бүртгэгдэж шалгагдсан гомдол мэдээллийн 29.6 хувийг Сонгуулийн тухай хуульд заасны дагуу Шүүхийн байгууллагуудад шилжүүлэн шийдвэрлүүлсэн гэжээ.

## Сонгуулийн тухай хууль

### 70 дугаар зүйл. Хууль бус сурталчилгааг хориглох

70.1. Ээлжит сонгуулийн жил эхэлснээс хойш санал хурааж дуустал аливаа этгээд сонгогчдын саналыг татах зорилгоор дараах үйлдэл, үйл ажиллагаа явуулахыг хориглоно:

70.1.1. мөнгө, эд зүйл тараах

70.1.3. аливаа үйлчилгээ төлбөргүйгээр болон хөнгөлөлттэй үзүүлэх

70.1.5. сонгогчдыг гадаад, дотоодод аялал зохион байгуулан оролцуулах, амралт, сувилалд амрах, сувилуулах.

Ажиглагчид мониторингид хамрагдсан тойргуудад УИХ-д суудалтай 3 намаас нэр дэвшсэн нийт 21 нэр дэвшигчийн сурталчилгааг хариуцан ажиллаж байсан сонгуулийн штабуудад очиж мөн мэдээлэл цуглуулахыг зорьсон. Сонгуулийн зардлыг бууруулах, тэгш өрсөлдөөнийг дэмжих үүднээс Сонгуулийн тухай хуульд «Нэр дэвшигч болон нам, эвсэл,

тэдгээрийн сонгуулийн штаб нь сонгуулийн хэсэг бүрт хоёроос илүүгүй ухуулах байр ажиллуулна» гэж зохицуулсан байдаг. Түүнчлэн хуульд сонгуулийн хэсгүүдийг байгуулж хэсгийн нутаг дэвсгэр, төвийг зарлах үүргийг сум, дүүргийн Иргэдийн

**Иргэдийн төлөөлөгчдийн хурлуудаас сонгуулийн хэсгүүд байгуулахдаа аль тойрогт хамаарахыг тодотгохгүй байгаа нь иргэний нийгмийн ажиглагчдад хүндрэл учруулж байв.**

хурлын тэргүүлэгчдэд хариуцуулжээ. 2016 оны сонгуулийн үйл явцаас харахад улсын хэмжээнд хаана байршилтай, хэдэн хэсгийн хороо байгааг нэгтгэсэн мэдээлэл олоход хүндрэлтэй байв. Үүний зэрэгцээ Иргэдийн төлөөлөгчдийн хурлуудаас сонгуулийн хэсгүүд байгуулахдаа аль тойрогт хамаарахыг тодотгохгүй байгаа нь иргэний нийгмийн ажиглагчдад хүндрэл учруулаад зогсохгүй сонгогчдын хувьд ойлгомжгүй байдал үүсгэж байсныг цаашид анхаарах нь зүйтэй. Иймээс мониторингид хамрагдсан 7 тойргийн хэмжээнд

олдсон мэдээлэлд үндэслэн ухуулах байрны зардлыг дараах байдлаар ойролцоолон тооцоолж гаргав.

№	Кампанит ажлын хүрээнд хийгдсэн ажлууд	Тоо (ширхэг)
	Ухуулах байр түрээсэлсэн	
1	Гэр - 66 Байр - 223	289
2	Зурагт хуудас, самбар байрлуулсан	1872
3	Сурталчилгааны самбар байрлуулсан	538

Сонгуулийн штабуудын дийлэнх нь дээр дурдсан гэр/байрны түрээс болон бусад үйл ажиллагаанд ямар зардал гаргаж буй талаар мэдээлэл өгөхөөс эрс татгалзаж байсан ба цөөн нэр дэвшигчийн өгсөн мэдээлэлд тулгуурлавал ухуулах байр түрээслэх дундаж үнэ 2016 оны сонгуулийн үеэр 300,000-400,000 төг, гэр түрээслэх үнэ 150,000 төг байжээ. Энэ үнэд үндэслэн ойролцоо тооцоо хийж үзэхэд мониторингид хамрагдсан 7 тойргийн ухуулах байрны түрээсийн нийт үнэ 100 орчим сая болохоор байна. Хийсэн ойролцоо тооцоог нарийвчлан харуулбал:

- Ухуулах байрны түрээс  $223 * 400,000$  (дундаж үнэ) = 89,200,000 төгрөг
- Гэр түрээсэлсэн нийт зардал дунджаар  $66 * 150,000 = 9,900,000$  төгрөг

Нэр дэвшигчдийн хувьд кампанит ажлын зардалтай нь холбоотой дараах хүснэгтэд үзүүлсэн мэдээллийг хүссэн боловч бүрэн гүйцэд мэдээлэл өгөх нэр дэвшигч байгаагүй. Харин мэдээлэл өгсөн УИХ-д суудалтай 3 гол нам болох АН, МАН, болон МАХН-аас дэвшсэн 21 нэр дэвшигчийн өгсөн тоо баримтыг нэгтгэвэл дараах дүр зураг харагдаж байна.



Зардлын төрөл	Нийт дүн (ширхгээр)	Мэдээлэл өгсөн нэр дэвшигчдийн тоо			Мэдээлэл өгөөгүй нэр дэвшигчид (хувиар)
		Хэвлэсэн	Хэвлээгүй	Нийт	
Ухуулах хуудас	88093	11	3	14	33%
Сонин*	63038	9	6	15	29%
Сэтгүүл	129442	11	4	15	29%
Тээврийн хэрэгсэл	325	18			14%
Сонгуулийн штабын шадар туслагч	333	Ажил- луулсан 10	Ажиллуу- лаагүй 4	Нийт 14	33%
Сонгуулийн штабын ухуулагч	872	Ажил- луулсан 11	Ажиллуу- лаагүй 4	Нийт 15	29%
Намтар	42858	Тараасан 5	Тараагаа- гүй 14	Нийт 19	10%
Мөрийн хөтөлбөр	7210	Тараасан 2	Тараагаа- гүй 18	20	5%

\* Сонины хувьд «намаас өгсөн» гэж хариулсан нэр дэвшигчдийг сонин гаргаагүйд оруулж тооцлоо.

\* Бүх хэвлэмэл материалын хувьд «өрхийн тоогоор» гэж тойм хариулаад зардлын талаар мэдээлэл өгөхөөс шууд татгалзсан нэр дэвшигчдийг мэдээлэл өгөхөөс татгалзсанд тооцов.

Сонгуулийн кампанит ажлын үеэр нэр дэвшигчид зардлын дансандаа хандив хүлээж авах, хуримтлагдсан хөрөнгийг сонгуулийн зорилгоор буюу хуулиар зөвшөөрсөн үйл ажиллагаанд зарах эрх нь нээлттэй ч үүнийг хянах бололцоогүй, мэдээллийг ил тод болгох эрх зүйн орчин огт байхгүй байна. Улмаар сонгуулийн санхүүжилтийн мэдээлэл хамгийн хаалттай харанхуй үе нь сонгогчдод энэ мэдээлэл хамгийн их хэрэгтэй сонгуулийн кампанит ажлын үе болж таарч байгааг энд онцлох нь зүйтэй. Нэр дэвшигчид ямар эх үүсвэрээс санхүүжин түүнийгээ ямар үйл ажиллагаанд зарцуулж буйг мэдэх бололцоо сонгогчдын болон тэднийг төлөөлөн ажиллаж буй иргэний нийгмийн байгууллагуудын хувьд огт байхгүй байна. Энэ нь сонгогчид мэдээлэлтэй байж сонгох эрхээ бүрэн утгаар нь хэрэгжүүлэх эрх зөрчигдөж буйн илрэл юм.

### 3. Сонгуулийн дараах нам, эвсэл, нэр дэвшигчдийн зардлын тайлан иж бүрэн бус, хяналт тавихад бэрхшээлтэй байна

Сонгуулийн тухай хуульд зааснаар сонгуульд оролцсон нам, эвсэл, нэр дэвшигч санал хураалт явагдсан өдрөөс хойш хуульд заасан хугацаанд дараах үзүүлэлтээр зардлын дансны тайланг аудитаар хянуулан дүгнэлт гаргуулж СЕХ-нд хүлээлгэн өгөх ёстой. Үүний дараа СЕХ тайланг Төрийн аудитын байгууллагад хүргүүлэхийн сацуу, хуулбарыг Татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад хүлээлгэн өгөхөөр зохицуулагдсан.

Нэр дэвшигчид (санал хураалт явагдсан өдрөөс хойш 30 хоногт багтаан)	Нам, эвсэл (санал хураалт явагдсан өдрөөс хойш 45 хоногт багтаан)
1. Сонгуулийн зардлын дансанд орсон орлогын нийт хэмжээ. Үүнд: а. өөрийн хөрөнгөөс оруулсан орлого б. нам, хамтарсан намууд, эвслээс оруулсан орлого в. хандивын орлого. - хандивлагч иргэний эцэг (эх)-ийн нэр, өөрийн нэр, оршин суугаа газрын хаяг, хандивын хэмжээ, хэлбэр - хандивлагч хуулийн этгээдийн нэр, оршин байгаа газрын хаяг, гүйцэтгэх захирлын эцэг (эх)-ийн нэр, өөрийн нэр, хандивын хэмжээ, хэлбэр 2. Зарлагын ангилал, гүйцэтгэл 3. Үлдэгдлийн хэмжээ, байршил	1. Сонгуулийн зардлын данснаас зарлага гаргаж эхлэхийн өмнөх мөнгөн хөрөнгийн хэмжээ, эх үүсвэр (гүйлгээ тус бүрээр) 2. Сонгуулийн зардлын дансны зарлагын гүйлгээ нээсэн өдрөөс хойш хаагдах өдөр хүртэлх хугацаанд орсон орлогын хэмжээ 3. Сонгуулийн зардлын дансны зарлагын гүйлгээ нээсэн өдрөөс хойш хаагдах өдөр хүртэлх хугацаанд орсон орлогын эх үүсвэр (гүйлгээ тус бүрээр) 4. Зарлагын ангилал, гүйцэтгэл, гэрээний хамт 5. Үлдэгдлийн хэмжээ, байршил (нам, эвсэл хоёр буюу хэд хэдэн зардлын данстай бол данс тус бүрийн)

Хуульд нам, эвслийн зардлын тайлан нь мөнгөн ба мөнгөн бус хөрөнгийн тайлан байна (57.2) гэж заажээ. Нам, эвсэл, нэр дэвшигчдийн сонгуулийн зардлын данс байршуулсан банкны захирал, эсхүл салбарын эрхлэгч нь уг дансны бүх гүйлгээг нэгтгэсэн тайлан гаргаж, санал хураалт дууссан өдрөөс хойш сонгуулийн төв байгууллагад мөн хүргүүлэх үүрэг хүлээж буй.

Мониторингид хамрагдсан 7 тойрогт өрсөлдсөн нэр дэвшигчдийн ихэнх нь хуульд заасан хугацаанд зардлын тайлангаа СЕХ-нд хүргүүлсэн байна. ҮАГ-аас мэдээлснийг үзвэл СЕХ-ноос сонгуульд оролцсон талуудын тайланг 2016 оны 8 дугаар сарын 4 болон 15-ны өдөр тус тус хүргүүлжээ. ҮАГ-аас 2016 оны 11 дүгээр сарын 4-ний өдөр УИХ-ын сонгуулийн зардлын дүн, хандивын талаарх мэдээллийг цахим хуудсандаа нийтэлж ил болгосноос мониторингид хамрагдсан тойргуудын мэдээллийг тойрог тус бүрээр хүснэгтлэн харуулав.

**Сүхбаатар дүүргийн 60-р тойрогт нэр дэвшигчдийн зардлын дүн**  
(сая төгрөгөөр)

№	Нэр дэвшүүлсэн нам, эвслийн нэр	Нэр дэвшигчийн овог/нэр	Зардлын дээд хэмжээ	Зардлын гүйцэтгэл
1	МАН	Ц.Мөнх-Оргил	177,000.0	157,427.6
2	АН	Х.Тэмүүжин	177,000.0	122,624.9
3	ТТЭНЭ	А.Лхамдэгэд	177,000.0	29,524.0
4	ИЗНН	А.Баярхүү	177,000.0	13,094.2
5	БНН	А.Отгонболд	177,000.0	12,721.4
6	МСДН	Ж.Сандуйжав	177,000.0	1,185.6
7	МАХН	Л.Сэлэнгэ	177,000.0	13,750.9
8	ИХН	Р.Ууганбаяр	177,000.0	2,999.1
9	Бие даан	Г.Мөнхбаяр	177,000.0	10,901.2
10	Бие даан	Ц.Наранчимэг	177,000.0	26,278.6
	<b>Дүн</b>		<b>1,770,000.0</b>	<b>390,507.5</b>

**Сүхбаатар дүүргийн 61-р тойрогт нэр дэвшигчдийн зардлын дүн**  
(сая төгрөгөөр)

№	Нэр дэвшүүлсэн нам, эвслийн нэр	Нэр дэвшигчийн овог/нэр	Зардлын дээд хэмжээ	Зардлын гүйцэтгэл
1	МАН	С.Батболд	176,000.0	175,991.2
2	АН	М.Батчимэг	176,000.0	173,046.8
3	ТТЭНЭ	Б.Энхмаа	176,000.0	12,832.0
4	ИЗНН	С.Эрдэнэчимэг	176,000.0	-
5	БНН	П.Отгонбаяр	176,000.0	4,703.9
6	ИХН	Ж.Туул	176,000.0	5,060.8
7	МАХН	И.Энхтүшиг	176,000.0	7,925.7
8	МKN	М.Намсрай	176,000.0	470.1
	<b>Дүн</b>		<b>1,408,000.0</b>	<b>380,030.5</b>

**Баянзүрх дүүргийн 53-р тойрогт нэр дэвшигчдийн зардлын дүн**  
(сая төгрөгөөр)

№	Нэр дэвшүүлсэн нам, эвслийн нэр	Нэр дэвшигчийн овог/нэр	Зардлын дээд хэмжээ	Зардлын гүйцэтгэл
1	МАН	Б.Төмөрчулуун	192,000.0	131,128.7
2	АН	Ж.Батзандан	192,000.0	184,399.9
3	ТТЭНЭ	М.Шагдарсүрэн	192,000.0	2,389.0
4	МУНН	Б.Арго	192,000.0	2,204.0
5	БНН	Р.Төмөрбаатар	192,000.0	351.0
6	МСДН	Д.Ганзориг	192,000.0	-
7	МАХН	Д.Эдэнэцогт	192,000.0	9,968.6
8	ИХН	Р.Энхтуяа	192,000.0	22,949.4
9	Бие даан	Л.Өнөрчимэг	192,000.0	1,313.0
10	Бие даан	Д.Батбаяр	192,000.0	12,278.9
11	Бие даан	Ө.Эрдэнболд	192,000.0	17,761.6
12	Бие даан	Ж.Ганбаатар	192,000.0	-
	<b>Дүн</b>		<b>2,304,000.0</b>	<b>384,744.1</b>

**Баянзүрх дүүргийн 49-р тойрогт нэр дэвшигчдийн зардлын дүнг тухайн тойрогт зарцуулж болох зардлын дээд хэмжээтэй харьцуулсан дүн**

(сая төгрөгөөр)

№	Нэр дэвшүүлсэн нам, эвслийн нэр	Нэр дэвшигчийн овог/нэр	Зардлын дээд хэмжээ	Зардлын гүйцэтгэл
1	МАН	Д.Оюунхорол	206,000.0	202,100.8
2	АН	Д.Зоригт	206,000.0	168,286.5
3	ТТЭНЭ	О.Бум-Ялагч	206,000.0	32,620.3
4	МУНН	О.Алтанзул	206,000.0	28,078.5
5	БНН	Л.Батбаяр	206,000.0	324.2
6	МСДН	Р.Нарангэрэл	206,000.0	12,977.7
7	МАХН	С.Жаргал	206,000.0	45,453.9
8	МКН	Ц.Дулмаа	206,000.0	768.5
9	Бие даан	Г.Баасан	206,000.0	-
10	Бие даан	О.Алтангэрэл	206,000.0	121,662.9
11	Бие даан	Б.Батбаатар	206,000.0	-
12	Бие даан	А.Эрдэнэбилэг	206,000.0	-
	<b>Дүн</b>		<b>2,472,000.0</b>	<b>612,273.3</b>

**Өмнөговь аймгийн 22-р тойрогт нэр дэвшигчдийн зардлын дүн**  
(сая төгрөгөөр)

№	Нэр дэвшүүлсэн нам, эвслийн нэр	Нэр дэвшигчийн овог/нэр	Зардлын дээд хэмжээ	Зардлын гүйцэтгэл
1	МАН	Н.Амарзаяа	164,000.0	124,019.0
2	АН	Б.Бадраа	164,000.0	162,780.0
3	МАХН	Д.Эрдэнэ	164,000.0	-
	<b>Дүн</b>		<b>492,000.0</b>	<b>286,799.0</b>

**Өмнөговь аймгийн 23-р тойрогт нэр дэвшигчдийн зардлын дүн**  
(сая төгрөгөөр)

№	Нэр дэвшүүлсэн нам, эвслийн нэр	Нэр дэвшигчийн овог/нэр	Зардлын дээд хэмжээ	Зардлын гүйцэтгэл
1	МАН	Л.Энхболд	139,000.0	93,927.0
2	АН	Д.Бат-Эрдэнэ	139,000.0	139,970.0
3	МАХН	Б.Буджаргал	139,000.0	8,712.0
	<b>Дүн</b>		<b>417,000.0</b>	<b>242,609.0</b>

**Төв аймгийн 30-р тойрогт нэр дэвшигчдийн зардлын дүн**  
(сая төгрөгөөр)

№	Нэр дэвшүүлсэн нам, эвслийн нэр	Нэр дэвшигчийн овог/нэр	Зардлын дээд хэмжээ	Зардлын гүйцэтгэл
1	МАН	Н.Энхболд	103,000.0	82,828.1
2	АН	Д.Доржпүрэв	103,000.0	97,500.9
3	МАХН	О.Буяннэмэх	103,000.0	33,616.3
	<b>Дүн</b>		<b>309,000.0</b>	<b>213,945.3</b>

Төрийн аудитын байгууллагаас зардлын тайланд хийж буй хяналт нь зардлын нийт дүнг олон нийтэд тойм байдлаар зарлах, хуульд заасан тодорхой хэмжээнээс дээш хандив өгсөн хувь хүмүүс, хуулийн этгээдийн талаар мэдээлэл цацахаас цааш хэтрэхгүй байна. Сонгуулийн санхүүжилтийн ил тод байдлыг хангалттай түвшинд хангаж улс төрийн хүрээний авлигаас сэргийлэх томоохон бөгөөд чухал зорилгын төлөө ажиллахад иргэний нийгмийн хувьд энэ мэдээлэл огт хангалтгүй юм.

Төслийн багийн зүгээс мониторингид хамрагдсан 7 тойргийн нэр дэвшигчдийн зардлын тайланг дэлгэрэнгүйгээр нь авах хүсэлтээ

ҮАГ-т тавьсны дагуу Өмнөговь аймгийн 22, 23 дугаар тойргууд болон Төв аймгийн 30 дугаар тойргийн мэдээллийг тус газраас хүлээн авсан. Гэвч ҮАГ-ын зарим шинжээч мэдээлэл өгөхөөс үндэслэлгүй татгалзсаны улмаас Баянзүрх дүүргийн 49 болон 53 дугаар тойрог, мөн Сүхбаатар дүүргийн 61 дүгээр тойргуудад өрсөлдсөн нэр дэвшигчдийн мэдээллийг авах боломжгүй байв.

Бидэнд байгаа зардлын дансны дэлгэрэнгүй тайлангаар 23 нэр дэвшигчийн хувьд нийт 1,438,745,600 төгрөг буюу 1,5 тэрбум шахам төгрөгийг дансандаа төвлөрүүлснийг өмнө дурдсан. Харин энэ мөнгийг юунд зарцуулсныг нь тодорхойлоход маш түвэгтэй байв. Тухайлбал, бидэнд мэдээлэл нь ирсэн 23 нэр дэвшигчийн зөвхөн 10 нь зардлын дансны хуулгаа тайландаа хавсаргасан байх ба бусад нь огт хавсаргаагүй байв. Түүнчлэн бүх зардлын тайланд зарцуулалтыг нотлох ямар нэг хүчин төгөлдөр баримт огт хавсаргаагүй байна. Энэ тохиолдолд сонгуулийн зорилгоор зардлын дансанд хуримтлуулсан хөрөнгийг хуулийн дагуу зарцуулж байгаа эсэхийг хянах бололцоо байхгүй юм. Жишээлбэл, нэгэн нэр дэвшигч 2016 оны 6 дугаар сарын 9-нд зардлын дансандаа өөрийн нэрээр 139,000,000 төгрөг шилжүүлсэн байх агаад сонгуулийн кампанит ажил өрнөсөн 17 хоногийн хугацаанд ердөө 3 удаа гүйлгээ хийж дээрх мөнгийг зарцуулж дууссан атал юунд зарцуулах тухай дансны хуулганаас мэдэх боломжгүй байснаас гадна зарцуулалтыг хянах нотлох баримтгүй байх аж:

Огноо	Шилжүүлсэн дүн	Зориулалт/тайлбар
2016/6/9	3,475,000	Модем
2016/6/9	126,525,000	Хувь хүнд шилжүүлсэн, зориулалт тодорхойгүй.
2016/6/13	9,000,000	Өмнөх шилжүүлгийг хийсэн хувь хүний данс руу дахин энэ шилжүүлэг хийсэн, зориулалт тодорхойгүй.

Хуулийн дагуу эл нэр дэвшигч зардлын тайлангаа аудитаар хянуулсан байх ба тайланг хянасан аудитын дүгнэлтэд: «Бид аудитын ажлыг гүйцэтгэхдээ Сонгуулийн тухай хуулийн холбогдох заалтуудыг тус нэр дэвшигч хэрэгжүүлснийг нотлох үндэслэлтэй нотолгоог олж авахын тулд нягтлан бодох бүртгэлийн баримтууд, харилцах дансны хуулга, зардлын тайланг шалгалаа. ...Бидний дүгнэлтээр нэр дэвшигч Сонгуулийн тухай хуулийн дагуу үнэн зөв ажиллажээ.» гэсэн байв.

СЕХ-ноос жишээ болгон гаргасан загварын дагуу дээрх 139 сая төгрөгийн зардлын задаргааг дараах байдлаар тайлагнасан байх ба энэ нь дансны гүйлгээний хуулбараас харагдаж буй дээрх ерөнхий дүнтэй ойролцоо зарцуулалт л харагдахаас ямар нэг нотлох баримтаар баталгаажуулаагүй байв.

(мянган төгрөгөөр)

№	Үзүүлэлт	Мөнгөн дүн		Аудит-лагдсан
		Мөнгөн дүн	Мөнгөн бус	
ОРЛОГО	1 Нэр дэвшигчийн өөрийн хөрөнгө	139,000.0		139,000.0
	2 Хуулийн этгээдээс өгсөн хандив			
	3 Иргэдээс өгсөн хандив			
	4 Нам, хамтарсан нам, эвслээс оруулсан орлого			
	<b>Орлогын дүн</b>	<b>139,000.0</b>		<b>139,000.0</b>
ЗАРДАЛ	1 Сонгуулийн мөрийн хөтөлбөрийг тайлбарлан таниулах зардал	49,969.0		49,969.0
	2 Нам,эвсэл, нэр дэвшигчийг сурталчлах зардал	42,933.0		42,933.0
	3 Сонгуулийн уулзалт, хурал, цуглаан зохион байгуулах зардал	1,426.0		1,426.0
	4 Бичиг хэргийн зардал	5,759.0		5,759.0
	5 Шуудан холбооны зардал			
	6 Унаа, хоол, утасны зардал	27,685.0		27,685.0
	7 Албан томилолтын зардал	9,564.0		9,564.0
	8 Хөлс урамшууллын зардал			
	9 Бусад	1,634.0		1,634.0
	<b>ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>138,970.0</b>		<b>138,970.0</b>
	<b>ҮЛДЭГДЭЛ</b>			<b>30.0</b>

(мянган төгрөгөөр)

№	Үзүүлэлт	Мөнгөн дүн		Бүгд	Аудитлагдсан
		Мөнгөн дүн	Мөнгөн бус		
Орлого	1 Нэр дэвшигчийн өөрийн хөрөнгө	139,000.0			139,000.0
	2 Хуулийн этгээдээс өгсөн хандив				
	3 Иргэдээс өгсөн хандив				
	4 Нам, хамтарсан нам, эвслээс оруулсан орлого				
	<b>ОРЛОГЫН ДҮН</b>	<b>139,000.0</b>			<b>139,000.0</b>
Зардал	1 Сонгуулийн мөрийн хөтөлбөрийг тайлбарлан ганиулах зардал	49,969.0			49,969.0
	2 Нам, эвсэл, нэр дэвшигчийг сурталчлах зардал	42,933.0			42,933.0
	3 Сонгуулийн уулзалт, хурал, цуглаан зохион байгуулах зардал	1,426.0			1,426.0
	4 Бичиг хэргийн зардал	5,759.0			5,759.0
	5 Шуудан холбооны зардал				
	6 Унаа, хоол, утасны зардал	27,685.0			27,685.0
	7 Албан томилолтын зардал	9,564.0			9,564.0
	8 Хөлс, урамшууллын зардал				
	9 Бусад	1,634.0			1,643.0
	<b>ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>138,970.0</b>			<b>138,970.0</b>
<b>ҮЛДЭГДЭЛ</b>					<b>29.0</b>

*Нэр дэвшигчийн ирүүлсэн зарцуулалтын тайлангийн хуулбар*

Тухайн нэр дэвшигчийн хувьд хандив огт хүлээн аваагүй агаад зардлын дансанд орсон орлого болох 139 сая төгрөг нь өөрийн хөрөнгө гэж тайлбарласан байгаа юм. Сонгуулийн тухай хуульд зааснаар:

54.1. Нэр дэвшигч нь өөрийн хувийн орлогоор олсон мөнгөн хөрөнгийг нэр дэвшигчийн сонгуулийн зардлын дансанд оруулан сонгуулийн зардал гаргана.

54.2. Нэр дэвшигчийн хувийн орлогоор олсон мөнгөн хөрөнгө гэдэгт тухайн хувь хүний хөдөлмөрийн хөлс, түүнчлэн Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд заасан үйл ажиллагааны болон хөрөнгийн орлого хамаарна.

Хуулийн 60.2-т заасны дагуу СЕХ нь нам, эвсэл, нэр дэвшигчийн сонгуулийн зардлын тайланг нэг хувь олшруулан татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад хүргүүлэх ёстой. Харин тус байгууллагын хувьд ямар хэлбэрийн хяналт тавих тухай хуульд тодорхой заагаагүй орхисон ба 2016 оны УИХ-д оролцсон нам, эвсэл,



нэр дэвшигчдийн зардлын тайлангийн хуулбарыг хүлээн аваад ямар арга хэмжээ авч буй нь өнөөг хүртэл тодорхой биш байна.

Өмнө дурдсанчлан нэр дэвшигчдийн хувьд сонгуульд оролцохоор бүртгүүлэхдээ СЕХ-нд хөрөнгө орлогын мэдүүлгээ өгч буй боловч энэ мэдээлэл нь ил тод биш байгаа нөхцөлд сонгогчид, иргэний нийгмийн байгууллагууд дээрх нэр дэвшигчийн төрийн аудитын байгууллагад хүлээлгэн өгсөн шиг тайланд харьцуулсан дүн шинжилгээ хийж хяналт тавих бололцоо байхгүй байгааг онцлох нь зүйтэй.

Дээр дурдсан хуулийн заалтад тодорхой тусгасанчлан (54.1) өөрийн хөрөнгөөр сонгуулийн кампанит ажлын зардлаа санхүүжүүлсэн нэр дэвшигч сонгуулийн зардлын дансанд оруулж байж зарах ёстой хуулийн заалт байгаа ч бодит байдалд дараах зөрчлүүд гарч байна. Үүнд:

- Хувийн эзэмшлийн аж ахуйн нэгжийн дансны хуулгыг тайландаа хавсарган өгч, «...энэхүү аж ахуйн нэгж нь өөрийнх нь өмч тул нэр дэвшигч ийнхүү тайлагнаж байна» гэсэн хувийн аудитын дүгнэлтэйгээр тайлангаа ирүүлсэн жишээ байна. Зардлын тайланг заавал аудитаар хянуулж дүгнэлт гаргуулах хуультай атал «Хандивын хэмжээ бага учир аудитаар орох шаардлагагүй гэсэн мэдээллийн дагуу шууд СЕХ-нд сонгуулийн зардлын тайлангаа авч ирж өгөв» гэсэн тайлбар зүүсэн тайлан ирүүлсэн тохиолдол ч байна.

*Нэр дэвшигчийн ирүүлсэн мэдээллийн хуулбар*

Эдгээр нь бүгд илт хууль зөрчсөн үйлдэл байхад энэ талаар ҮАГ-аас гаргасан дүн мэдээлэлд огт дурдагдаагүй байх бөгөөд ямар арга хэмжээ авсан нь тодорхойгүй байв.

Аудитын байгууллагын хувьд хуулиар олгогдсон эрх хэмжээний хүрээнд нам, эвсэл, нэр дэвшигчид зардлын дансандаа:

- Хуулиар зөвшөөрсөн эх үүсвэрээс хандив хуримтлуулсан эсэх
- Хуримтлуулсан эсэхийг хуульд заасны дагуу зарцуулж тайлагнаж буй эсэхийг хянах үүрэг хуулиар хүлээж буй.

Түүнчлэн дээрх үүргээ хэрэгжүүлэхтэй холбоотой дараах эрхийг эдлүүлэхээр хуульд заасан.

### **Сонгуулийн тухай хууль**

#### **60 дугаар зүйл. Сонгуулийн зардлын тайлангийн хяналт**

60.4.1. нам, эвсэл, нэр дэвшигчийн авсан хандив, санхүүжилт болон зарцуулалтад дангаараа болон төрийн бусад байгууллагатай хамтран хяналт тавих

60.4.2. нам, эвсэл, нэр дэвшигчээс холбоотой мэдээлэл авах

60.4.3. сонгуулийн санхүүжилт, түүний зарцуулалтад гарсан зөрчлийн талаар баримт бичиг үйлдэх, бүрдүүлэх

60.4.4. төрийн болон бусад байгууллага, албан тушаалтан, иргэдээс сонгуулийн санхүүжилттэй холбоотой баримт бичгийг гаргуулан авах.

Энэ үүргээ төрийн аудитын байгууллага хэрхэн биелүүлж байгаа нь тодорхойгүй байгаа бөгөөд энэ талаар мониторингийн багийн зүгээс илгээсэн асуултуудад хариулт өгөхөөс татгалзсан болно. Энэ нь Аудитын байгууллага хуульд заасан эрхийнхээ хүрээнд нам, эвсэл, нэр дэвшигчдийн сонгуулийн санхүүжилтэд бүрэн гүйцэд хяналт хийхгүй байна гэж дүгнэж болохоор байна.

Сонгуулийн зардлын дансанд төвлөрч байгаа зардлыг бөөнөөр нь бэлнээр авч зарцуулсан тохиолдол маш их байгаагаас гадна зардлын дансны зарим гүйлгээ нь бодитой эсэх нь эргэлзээтэй жишээ цөөнгүй байна. Нэг жишээ дурдахад: Орон нутгийн тойрогт нэр дэвшсэн, тухайн орон нутагтаа байнга оршин суудаггүй нэр дэвшигчид шуудан холбоо, шатахуун унааны зардлаа огт тайлагнаагүй тохиолдол хэд хэд байна.

№	Нэр	Мөнгөн дүн	
		Мөнгөн дүн	Мөнгө
4	Иргэдээс өгсөн хандив	100,000,000	-
	Нам, хамтарсан нам, эвслээ оруулсан орлого	-	-
	<b>ОРЛОГЫН ДҮН</b>		
1	Сонгуулийн мөрийн хөтөлбөрийг тайлбарлан таниулах зардал	100,000,000	-
2	Нам, эвсэл, нэр дэвшигчийг сурталчлах зардал	15,200,000	-
3	Сонгуулийн уулзалт, хурал, цуглаан зохион байгуулах зардал	41,500,000	-
4	Бичиг хэргийн зардал	6,956,000	-
5	Шуудан холбооны зардал	620,500	-
6	Унааны зардал	23,500	-
7	Албан томилолтын зардал	35,700,000	-
8	Хөлс, урамшууллын зардал	-	-
	<b>ЗАРДЛЫН ДҮН</b>		
	<b>ҮЛДЭГДЭЛ</b>	<b>100,000,000</b>	<b>-</b>

		Мөнгөн дүн	
		Мөнгөн дүн	Мөнгө
4	Иргэдээс өгсөн хандив	40,000,000.00	40,000,000.00
	Нам, хамтарсан нам, эвслээ оруулсан орлого	4,100,000.00	4,100,000.00
	<b>ОРЛОГЫН ДҮН</b>	<b>2,000,000.00</b>	<b>2,000,000.00</b>
1	Сонгуулийн мөрийн хөтөлбөрийг тайлбарлан таниулах зардал	101,120,000.00	101,120,000.00
2	Нам, эвсэл, нэр дэвшигчийг сурталчлах зардал	38,155,556.00	38,155,556.00
3	Сонгуулийн уулзалт, хурал, цуглаан зохион байгуулах зардал	18,468,725.00	18,468,725.00
4	Бичиг хэргийн зардал	2,000,000.00	2,000,000.00
5	Шуудан холбооны зардал	23,600,000.00	23,600,000.00
6	Унааны зардал	-	-
7	Албан томилолтын зардал	-	-
8	Хөлс, урамшууллын зардал	-	-
	<b>ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>80,828,081.00</b>	<b>80,828,081.00</b>
	<b>ҮЛДЭГДЭЛ</b>	<b>20,291,919.00</b>	<b>20,291,919.00</b>

*Орон нутагт нэр дэвшигчийн зарим тайлангийн хуулбар*

Дээрх тайлангууд нь орон нутагт нэр дэвшигчийнх бөгөөд аудитын тамга тэмдэг тавигдаж баталгаажсан байгаа хэдий ч шуудан холбоо, шатахууны зардал тусгагдаагүй байна.

Гэтэл нэр дэвшсэн орон нутагтаа байнга оршин суудаг өөр нэг нэр дэвшигч сонгуулийн кампанит ажлын 17 хоногийн хугацаанд нийт 54,755,942 төгрөгийг унаанд зарсан гэж тайлагнажээ.

№	Үзүүлэлт	Мөнгөн дүн		Бүгд
		Мөнгөн дүн	Мөнгөн бус дүн	
Орлого	1 Нэр дэвшигчийн өөрийн хөрөнгө			-
	2 Хуулийн этгээдээс өгсөн хандив	30,000,000		30,000,000
	3 Иргэднээс өгсөн хандив	132,780,000		132,780,000
	4 Нам, хамтарсан нам эвслээс оруулсан орлого			-
	<b>ОРЛОГЫН ДҮН</b>	<b>162,780,000</b>	<b>-</b>	<b>162,780,000</b>
Зардал	1 Сонгуулийн мөрийн хөтөлбөрийг тайлбарлан таниулах зардал	71,010,000		71,010,000
	2 Нам, эвсэл, нэр дэвшигчийг сурталчлах зардал	13,016,200		13,016,200
	3 Сонгуулийн уулзалт, хурал, цуглаан зохион байгуулах зардал	1,660,000		1,660,000
	4 Бичиг хэргийн зардал	1,266,897		1,266,897
	5 Шуудан холбооны зардал	13,180,961		13,180,961
	6 Унааны зардал	54,755,942		54,755,942
	7 ХХОАТ өглөг	7,890,000		7,890,000
	8 Хөлс, урамшууллын зардал			-
	<b>ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>162,780,000</b>	<b>-</b>	<b>162,780,000</b>
	<b>ҮЛДЭГДЭЛ</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>

*Орон нутгийн нэр дэвшигчийн унааны зардал бүхий тайлангийн хуулбар*

Дээрх дүнг дансны гүйлгээний мэдээлэлтэй тулган харвал шатахуунд бэлнээр 27,000,000 төг зарцуулсан нь харагдана:

**Дансны гүйлгээний мэдээлэл**

Огноо	Шилжүүлсэн дүн	Зориулалт/тайлбар
2016/6/18	10,000,000 төг	Шатахууны үнэ - данснаас бэлнээр гаргасан
2016/6/21	17,000,000 төг	Шатахууны зардал/дараа тооцоо

Гэтэл дээрх нэр дэвшигчийн зардлын тайланд аудитын хийсэн тодруулгыг харвал «Уг нэр дэвшигч нь 52,722,100 төгрөгийг шатахуунд зарцуулсан байна» гэжээ.

2016 оны 6 дугаар сарын 29

**УЛСЫН ИХ ХУРЛЫН 2016 ОНЫ СОНГУУЛИЙН  
22 ДУГААР ТОЙРОГТ НЭР ДЭВШИГЧ Б.БАДРААГИЙН  
СОНГУУЛИЙН ОРЛОГО, ЗАРДЛЫН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА**  
2016 оны 06 дугаар сарын 29-нөөр

УИХ-ын сонгуулийн 22-р тойрогт “Ардчилсан нам”-аас нэр дэвшигч Бадамгаравын Бадраагийн сонгуулийн зардлын хөрөнгө бүрдүүлэлт Сонгуулийн тухай хуулийн дагуу 162,780.0 мянган төгрөгийн эх үүсвэр бүрдүүлж, кассаар бэлэн мөнгөөр 148,570.0 мянган төгрөг, харилцааар бэлэн мөнгөөр 14,210.0 мянган төгрөг, нийт 162,780.0 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Аудитад ирсэн баримтанд кассаас зарцуулсан мөнгөний зарцуулалттай холбоотой зарцуулалтыг нотлох дэмжих баримтуудыг хавсаргасан байна.

Шатахуунд 52,722.0 мянган төгрөг, хэвлэлд 13,181.0 мянган төгрөг, зар сурталчилгаанд 13,016.2 мянган төгрөг, унаа, хоол, буудалд 2,033.9 мянган төгрөг, бичиг хэргийн зардалд 1,267.9 мянган төгрөг, түрээсийн зардалд 1,660.0 мянган төгрөг зарцуулсан байна.

Сонгуулийн сурталчилгааны үеэр ухуулгын ажилд оролцсон 137 хүнд 4 удаагийн олголтоор өдрийн хоол, унаа, утасны мөнгөнд 78,900.0 мянган төгрөг олгосноос хувь хүний орлогын албан татвар 7,890.0 мянган төгрөг суутгаж төсөвт төвлөрүүлсэн байна.

*Аудитын дүгнэлтийн хуулбар*

Үндэсний статистикийн газрын мэдээллээс үзвэл УИХ-ын сонгуулийн кампанит ажил өрнөсөн 2016 оны 6 дугаар сард шатахууны улсын дундаж үнэ 1,534 төг байжээ. Энэ үнэд үндэслэн тооцвол дээрх нэр дэвшигч 34,369 (52,722,100/1534 = 34,369) литр шатахуун хэрэглэсэн дүн гарч байна. Нэр дэвшигчийн хувьд хэдэн машин сурталчилгаанд хэрэглэсэн нь зардлын тайлангаас тодорхой

харагдаагүй. Юутай ч энэ хэмжээний шатахууныг *Land Cruiser 200* маркийн нэг машинд хэрэглэхээр тооцвол уг нэр дэвшигч өөрийн тойргоо 80 удаа, Монгол Улсыг<sup>2</sup> бүхэлд нь дунджаар 20 орчим удаа тойрох бололцоотой.

---

<sup>2</sup> Монгол Улсын хилийн нийт периметр нь 8220 км. <[http://asem11.mn/?page\\_id=1822&lang=mn](http://asem11.mn/?page_id=1822&lang=mn)>



## ДҮГНЭЛТ

---

Монгол Улс авлигатай тэмцэх асуудлыг чухалчлан авч үзэж Авлигын эсрэг НҮБ-ын Конвенцэд нэгдэж, улмаар 2006 онд Авлигын эсрэг хууль батлан мөрдөх болсоор нэлээд хэдэн жилийн нүүр үзлээ. Гэвч энэ хугацаанд өндөр түвшний буюу улс төрийн хүрээн дэх авлигын асуудал тулгамдсан хэвээр байгааг Авлигатай тэмцэх газраас хийсэн удаа дараагийн судалгааны дүн харуулна. Улс төрийн хүрээнд шударга ёсыг бэхжүүлэхэд нэн түрүүнд анхаарах ёстой асуудал нь улс төрийн санхүүжилтийн ил тод байдал юм.

2016 оны 11 дүгээр сард УИХ-ын тогтоолоор баталсан «Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр»-ийн нэг зорилт нь улс төрийн санхүүжилттэй холбоотой асуудал болж тодорхойлогджээ. Үүнд:

«Улс төрийн намын болон сонгуулийн санхүүжилт, санхүүгийн харилцааг сайжруулах, олон нийтэд ил тод, нээлттэй болгох, улс төрийн үйл ажиллагаанд ардчилсан ёс, улс төрийн соёлыг нэвтрүүлэх замаар улс төрийн хүрээний авлигыг бууруулах, шударга ёсыг бэхжүүлэх хууль тогтоох болон гүйцэтгэх эрх мэдлийн байгууллагад бизнесийн бүлэглэлийн хууль бус ашиг сонирхол, нөлөөллийг бууруулах, цаашид учирч болзошгүй нөлөөллөөс урьдчилан сэргийлэх»

Сонгуулийн санхүүжилт нь ямар ч утгаараа улс төрийн санхүүжилтийн чухал бүрэлдэхүүн хэсэг юм. Уг мониторингийн дүнгээс үзэхэд манай улсад сонгуулийн зардлын ил тод байдлыг хангах эрх зүйн орчин туйлын дутмаг байгаагийн зэрэгцээ одоо хүчин төгөлдөр үйлчилж байгаа зохицуулалтуудын хэрэгжилт болоод хяналт нь маш хангалтгүй байна. Тухайлбал:

- 2015 онд батлагдсан сонгуулийн тухай шинэ хуульд сонгууль болохоос өмнө улс төрийн намуудын хүлээн авсан хандивын мэдээлэл, нэр дэвшигчдийн хөрөнгө орлогын мэдүүлэг зэргийг авч байх зохицуулалтыг нэмсэн нь сайшаалтай. Харин холбогдох хуулийн хүрээнд энэ мэдээлэл ил тод байх ёстой ч хариуцсан төрийн байгууллагууд нь мэдээлэл өгөхдөө хойрго, болгоомжилсон байдалтай хандаж байгаа нь олон нийт дээрх мэдээллийг авах боломжгүй болгож байна.
- Сонгогчдын хувьд мэдээлэл хамгийн их шаардлагатай сонгуулийн кампанит ажлын үеэр нам, эвсэл, нэр дэвшигч хаанаас санхүүжиж, түүнийгээ юунд зарцуулж байгааг мэдэх бололцоо байхгүй байгаа бөгөөд үүнийг зохицуулах эрх зүйн орчин алга байна.
- Хуульд сонгуульд оролцож буй нам, эвсэл, нэр дэвшигчид сонгуулийн зардлын нэг данстай байж түүнийхээ орлого, зарлагыг мэдээлэх замаар сонгуулийн санхүүжилтийн ил тод байдлыг хангах зохицуулалт хийсэн байгаа ч түүнд тавих хяналт сул байна. Үүнд:
  - Үндэсний аудитын газрын мэдээлснээр 2016 оны УИХ-д оролцсон 498 нэр дэвшигчийн 112 нь тайлангаа өгөөгүй.

- Хуулиар зардлын тайланг СЕХ-оор дамжуулан ҮАГ-т хүлээлгэн өгөхөөс өмнө аудитаар хянуулах ёстой ч энэ хяналт нэр төдий нийгдэж байна.
  - Нэр дэвшигчдийн зардлын тайлан бүрэн бус, өгсөн тоо баримт нь эргэлзээтэй байгаа ч түүнд ҮАГ хуулиар хүлээсэн үүргийнхээ дагуу зохих хяналт тавьдаг эсэх нь тодорхойгүй байна.
- Хуульд сонгуулиас хойш 4 сар орчмын дараа нам, эвсэл, нэр дэвшигчдийн санхүүжилтийн мэдээллийг ил болгохоор зохицуулсан. Гэвч энэ нь цаг хугацааны хувьд хожуу байгаагийн зэрэгцээ:
- Сонгуульд ажиглалт хийж буй иргэний нийгмийн байгууллагуудын хувьд мэдээллийг иж бүрнээр олж авч хяналт тавих бололцоогүй болгож байна.
  - Нийтэд ил болгож буй мэдээлэл нь хяналтын зорилгоор ашиглахад хангалтгүй, ач холбогдол багатай тойм төдий байна.
- Төрийн эх үүсвэрийг сонгуульд ашиглах, сонгогчдын саналыг худалдан авах үйлдэл сонгуулийн албан ёсны кампанит ажлын үеэр өмнөхтэй харьцуулахад бага гарах болсныг мониторингийн дүн харуулж байгаа хэдий ч дээрх үйлдлийг хориглосон хуулийн хугацаа эхлэхээс өмнө сонгогчдод эд зүйл тараах, төлбөргүй болон хөнгөлөлттэй үнээр үйлчилгээ сувилгаа үзүүлэх, аялал зугаалга болон амралтад явуулах гэх мэт үйлдэл гарсан талаар хэвлэл мэдээллийн хэрэгслээр хэд хэдэн удаа мэдээлснийг дурдууштай.





## ЗӨВЛӨМЖ

---

Монгол Улсад сонгуулийн санхүүжилтийг зохицуулсан хуулийн зохицуулалт тодорхой хэмжээгээр боловсронгуй болж сайжирсаар байгаа ч хэрэгжилт нь хангалтгүй, санхүүжилтийн мэдээлэл ил тод, хяналт сул байсаар өнөөг хүрчээ. Энэ асуудлыг шийдэхэд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхэд нь чухал гэж үзэж байна. Үүнд:

- Сонгуулийн зардлын дансыг шилэн болгох шаардлагыг хуульд тусгах, ингэхдээ дансанд хуримтлагдаж буй хандив, бусад эх үүсвэрээс орж ирж буй орлого, зардлын гүйлгээг сонирхсон этгээд сонгуулийн кампанит ажлын бүхий л хугацаанд харах боломжтой болгох, хууль хэрэгжүүлээгүй этгээдэд хүлээлгэх хариуцлагыг тодорхой заах;
- Улс төрийн нам, эвсэл, нэр дэвшигч сонгуулийн кампанит ажлын хугацаанд хандивын болон зардлын дүнгээ тодорхой давтамжтайгаар олон нийтэд тайлагнах шаардлагыг хуулиар тогтоох;

- Сонгуулийн дараах зардлын дансны тайланг гаргах журам, зааврыг гарын авлага хэлбэрээр тодорхой тайлбарлан гаргах үүргийг төрийн холбогдох байгууллагуудад хүлээлгэх, үүнд Монгол Улсын Нягтлан бодох бүртгэлийн хуульд нийцүүлэн, зардлуудыг баримтжуулан тайлагнадаг байх шаардлага тавьж тайлангийн загвар, стандартыг сайжруулах;
- Мөнгөн бус хандивыг хэрхэн дэлгэрэнгүй баримттай тайлагнах талаар тодорхой заавар, тайлангийн маягт, загвар гаргаж мөрдүүлэх;
- Сонгуулийн өмнө дээрх зардлын тайланг бэлтгэх, нээлттэй мэдээлэх талаар сонгуульд оролцох нам, эвсэл, нэр дэвшигчид мэдээлэл өгч, суралцах боломжоор хангах;
- Төрийн аудитын зүгээс зардлын тайланг хянахдаа хандивын эх үүсвэрээс эхлээд зардал тус бүрийн бодитой, хуульд нийцэж буй эсэхийг нягтлан бүрэн хяналт тавьж, дүнг нийтэд мэдээлэх ёстойг хуулиар тодорхой болгох;
- Зардлын дансны тайланд алдаатай мэдээлэл санаатай оруулсан нь тогтоогдвол хүлээлгэх хариуцлагыг тодорхой болгох;
- Зардлын данснаас гадуур сонгуулийн санхүүжилттэй холбоотой аливаа харилцаа явагдаж буй эсэхэд үр дүнтэй хяналт тавих бололцоог иргэний нийгмийн ажиглагчдад олгон сонгуулийн үеэр мэдээллийн ил тод байдлыг нэмэгдүүлэх зохицуулалтыг хуульд тусгах;
- Сонгуулийн өмнө болон явцад, түүнчлэн сонгууль дууссаны дараа санхүүжилтийн мэдээллийг ил тод, нээлттэй болгох механизм, арга хэлбэрийг тодорхой зааж, хэрэгжилтийг хангахад анхаарах.

# ХАВСРАЛТУУД

## Хавсралт 1. Төрийн байгууллагуудаас ирүүлсэн албан бичгүүд

### А. Цагдаагийн ерөнхий газрын албан бичиг №1



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОХИРУУЛАГЧ АГЕНТЛАГ

**ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР**

14201 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 4 дүгээр хороо,  
Самбуугийн гудамж 18, Утас: 7011-5507, Факс: 7011-5507,  
Web: www.police.gov.mn, E-mail: info@police.gov.mn

2016.10.07 № 58/4994  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

Хүсэлтийн хариу хүргүүлэх тухай

НЭЭЛТТЭЙ НИЙГЭМ ФОРУМЫН  
ЗАСАГЛАЛЫН ХӨТӨЛБӨРИЙН МЕНЕЖЕР  
Д.ЭНХЦЭЦЭГ ТАНАА

Цагдаагийн ерөнхий газарт хандаж ирүүлсэн таны хүсэлттэй танилцлаа.

Монгол Улсын Сонгуулийн тухай хуульд зааснаар сонгуультай холбоотой зөрчлийг цагдаагийн байгууллага шалгаж, шүүх шийдвэрлэхээр хуульчилсан байна.

Энэ үүргийн хүрээнд 2016 оны УИХ-ын болон аймаг, нийслэлийн, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын ээлжит сонгуулийн үйл ажиллагаатай холбоотой иргэд байгууллагаас ирүүлсэн гомдол, мэдээллийг хүлээн авч, шалгаад хуульд заасны дагуу шийдвэрлэж байна.

Дээрх 3 шатны сонгуулийн үйл ажиллагаатай холбоотой цагдаагийн байгууллагад ирүүлсэн гомдол мэдээллийн эцсийн шийдвэрлэлт зөвхөн цагдаагийн байгууллагаас хамаарахгүй бөгөөд сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн сонгуулийн үйл ажиллагаа дуусаагүй байгаа байдлаас нэгдсэн дүн, мэдээ гарах боломжгүй байгааг мэдэгдье.

ГХТА-НЫ ХЭРЭГ БҮРТГЭХ ХЭЯТСИЙН ДАРГА,  
ЦАГДААГИЙН ХУРАНДАА Ц.ОЧГЭРЭЛ

**Б. Цагдаагийн ерөнхий газрын албан бичиг №2**



**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОХИРУУЛАГЧ АГЕНТЛАГ  
ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР**

14201 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 4 дүгээр хороо,  
Самбуугийн гудамж 18, Утас: 7011-5507, Факс: 7011-5507,  
Web: www.police.gov.mn, E-mail: info@police.gov.mn

2016.11.01 № 58/5452

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

**НЭЭЛТТЭЙ НИЙГЭМ ФОРУМЫН  
ЗАСАГЛАЛЫН ХӨТӨЛБӨРИЙН МЕНЕЖЕР  
Д.ЭНХЦЭЦЭГ ТАНАА**


Цагдаагийн ерөнхий газарт хандаж ирүүлсэн хүсэлттэй танилцлаа.

Улсын Их Хурал, Аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2016 оны ээлжит сонгуулийн үеэр цагдаагийн байгууллагад иргэд, байгууллагаас сонгуулийн үйл ажиллагаатай холбоотой нийт 1399 гомдол, мэдээлэл ирүүлснийг бүртгэн шалгасан.

Сонгуулийн тухай хуулийн 70 дугаар зүйлийн 70.1.1, 70.1.3, 70.1.5 дахь заалтыг зөрчсөн гэх 158 гомдол, мэдээлэл бүртгэгдсэн нь ирүүлсэн нийт гомдол, мэдээллийн 11.9 хувийг эзлэж байна.

Цагдаагийн байгууллагад бүртгэгдэн шалгагдсан гомдол, мэдээллийн 29.6 хувийг Сонгуулийн тухай хууль тогтоомжинд заасны дагуу харьяалах Шүүхийн байгууллагуудад шилжүүлэн шийдвэрлүүлсэн байна.

Хүлээн авч, танилцана уу.

ГХТА-НЫ ХЭРЭГ БҮРТГЭХ ХЭЛТСИЙН  
ДАРГА, ЦАГДААГИЙН  
ХУРАНДАА  Ц.ОЧГЭРЭЛ

0917913

## В. Сонгуулийн ерөнхий хорооны албан бичиг



### МОНГОЛ УЛС СОНГУУЛИЙН ЕРӨНХИЙ ХОРОО АЖЛЫН АЛБА

Улаанбаатар-38  
Ж.Самбуугийн гудамж-11, Засгийн газрын XI байр  
Утас: 26-09-75, Факс: 32-69-75,  
E-mail: gecm@mongol.net  
http://www.gec.gov.mn

2016.6.12 № 136  
танай \_\_\_\_\_-ны № 07/16 -Т

Хариу хүргүүлэх тухай

ШУДАРГА СОНГУУЛИЙН ТӨЛӨӨ  
ИРГЭНИЙ НИЙГМИЙН ХЯНАЛТ  
СҮЛЖЭЭНД

Нам, эвсэл, нэр дэвшигчдийн зардлын тайланг гаргах, хянахтай холбоотой харилцааг Сонгуулийн тухай хуулийн 40-60 дугаар зүйлээр зохицуулна. Сонгуулийн зардлын тайлангийн загварын төслийг хүргүүлж байна. Уг загвар нь Хорооны хуралдаанаар хэлэлцэх явцад өөрчлөгдөх боломжтойг анхаарна уу. Сонгуулийн Ерөнхий Хорооны 2016 оны 08 дугаар тогтоолоор батлагдсан "Сонгуулийн штабын ажилтан, менежер, шадар туслагч, ухуулагчийн өдөр тутмын үйл ажиллагааны зардал гаргах журам"-ыг Хорооны цахим хуудсанд байрлуулсан тул тэндээс авч үзэж болно.


Нам, эвсэл, нэр дэвшигчдийн сонгуулийн зардлын дансны мэдээлэл бүрэн ирж дуусаагүй байх тул нэгтгэсний дараа Хорооны цахим хуудсанд байрлуулна.

Сонгуульд оролцохоор бүртгүүлсэн нам, эвслийн сүүлийн нэг жилийн хугацаанд иргэн, хуулийн этгээдээс хүлээн авсан хандивын төрийн аудитын байгууллагаар хянуулж баталгаажуулсан тайланг хянаж баталгаажуулсан Төрийн аудитын байгууллага болон нам, эвсэлд хандаж авна уу.

Авлигатай тэмцэх газрын 2012 оны 196 дугаар тушаалаар батлагдсан "Албан тушаалтны хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгийн талаар мэдээлэх, мэдээлэл өгөх журам"-д сонгуульд нэр дэвшигчийн хөрөнгө орлогын мэдүүлгийг нийтэд мэдээлэх, мэдээлэл өгөх тухай тусгагдаагүй байх тул ХОМ-ыг хуулбарлан өгөх боломжгүй байна. Энэ талаар Авлигатай тэмцэх газарт хандана уу.

Хавсралт 5 хуудастай.

ДАРГА



Д.БАЯНДҮҮРЭН

## Г. Авлигатай тэмцэх газрын албан бичиг



### МОНГОЛ УЛС АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗАР

14250 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,  
Сөүлийн гудамж 41, Утас: 7011-0251, Факс: (978) 7011-2460,  
E-mail: comcor@aac.mn, http://aac.mn

2016.06.24 № 05/4185.  
танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -Т

Хариу хүргүүлэх тухай

ШУДАРГА СОНГУУЛИЙН ТӨЛӨӨ  
ИРГЭНИЙ НИЙГМИЙН ХЯНАЛТ  
СҮЛЖЭЭНИЙ ГИШҮҮН  
З.УЯНГА, Д.ЭНХЦЭЦЭГ НАРТ  
/УТАС:99092086/

Тус газарт ирүүлсэн "Мэдээлэл хүсэх тухай" албан бичгийг хүлээн авч хянан үзлээ.

Улсын Их Хурал, бүх шатны иргэдийн Төлөөлөгчдийн хурлын сонгуульд нэр дэвшигч нь Авлигын эсрэг хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.6-д заасны дагуу энэхүү хуулийн үйлчлэлд хамаарах бөгөөд мөн хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2 дахь хэсэгт заасны дагуу хөрөнгө, орлогын мэдүүлэг нь олон нийтэд нээлттэй байна.

Авлигын эсрэг хуулийн 10 дугаар зүйлийн 10.6 дахь хэсэгт заасны дагуу Улсын Их Хурлын сонгуульд нэр дэвшигч нь хөрөнгө, орлогын мэдүүлгээ Сонгуулийн ерөнхий хороонд гаргаж өгдөг тул Авлигатай тэмцэх газрын даргын 2012 оны 10 дугаар сарын 11-ний өдрийн 196 дугаар тушаалын 2 дугаар хавсралтаар батлагдсан "Албан тушаалтны хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгийн талаар мэдээлэх, мэдээлэл өгөх" журамд заасныг үндэслэн нэр дэвшигчдийн талаарх мэдээллийг Сонгуулийн ерөнхий хорооноос гаргуулан авах нь зүйтэй.

Сонгуулийн ерөнхий хороонд мэдээлэл авах хүсэлт гаргахдаа дээрх журмын 4 дүгээр зүйлийн 4.2 дахь хэсэгт заасныг баримтлан батлагдсан маягтын дагуу гаргах шаардлагатай. Тухайн байгууллага нь мөн журмын 1 дүгээр хавсралтаар батлагдсан загварын дагуу нэр дэвшигчийн хөрөнгө, орлогын мэдүүлгийн талаарх мэдээллийг хураангуй хэлбэрээр гаргаж өгөх зохицуулалттай юм.

Мөн албан бичигт дурдсан сонгуулийн тойргуудад нэр дэвшиж байгаа Монгол Ардын нам, Ардчилсан намын зарим нэр дэвшигчдийн хөрөнгө, орлогын мэдүүлгийн талаарх мэдээлэл нь "Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 2016 оны 5 дугаар сарын 5-ны өдрийн №18/927/ дугаарт хэвлэгдсэн ба Авлигатай тэмцэх газрын <http://www.xacxom.aac.mn> цахим мэдээллийн сүлжээнд мөн байршиж байгаа болно.

ХЯНАЛТ ШАЛГАЛТ, ДҮН  
ШИНЖИЛГЭЭНИЙ ХЭЛТСИЙН  
ДАРГА, ЭРХЭЛСЭН КОМИССАР

Ж.БАТСАЙХАН



008451

## Хавсралт 2. Мониторингийн багийн гишүүд

**А. Нийслэлийн Баянзүрх дүүргийн 49, 53 ба Сүхбаатар дүүргийн 60, 61-р тойрогт**

	Нэр	Албан тушаал
1	З.Уянга	«Филантропи хөгжлийн төлөө төв» ТББ-ын гишүүн, өмгөөлөгч, төслийн удирдагч
2	Д.Сүнжид	«Филантропи хөгжлийн төлөө төв» ТББ-ын Зөвлөх, хууль зүйн ухааны доктор (PhD)
3	Х.Эрдэм-Ундрах	«Филантропи хөгжлийн төлөө төв» ТББ-ын гишүүн, хууль зүйн ухааны доктор, (PhD)
4	Д.Эрдэнэчимэг	Судлаач
5	А.Алтанзул	Судлаач
6	С.Ариунтунгалаг	Судлаач
7	А.Пүрэвдолгор	Туслах ажилтан
8	Я.Бадамдорж	Туслах ажилтан
9	О.Амартүвшин	Төслийн ажилтан
10	С.Жаргалсайхан	Төслийн ажилтан
11	Т.Төгсван	Төслийн ажилтан
12	В.Бат-Оргил	Төслийн ажилтан
13	Б.Оюунсүвд	Төслийн ажилтан
14	Л.Баасандорж	Төслийн ажилтан
15	Б.Нандин-Эрдэнэ	Төслийн ажилтан
16	А.Гүррагчаа	Төслийн ажилтан

**Б. Өмнөговь аймгийн 22, 23-р тойрогт**

	Нэр	Ажилласан сум багийн нэр
17	Б.Зандраа	Төслийн удирдагч
18	С.Энэбиш	Төслийн менежер
19	Д.Давааням	Төслийн багийн гишүүн
20	Б.Батжаргал	Төслийн багийн гишүүн
21	Д.Уламбаяр	Төслийн багийн гишүүн
22	А.Улаанцэцэг	ДЗ 3-р баг
23	Б.Батчулуун	ДЗ 6-р баг
24	Л.Мөнхтуяа	ДЗ 2-р баг
25	Т.Билэгсайхан	ДЗ 5-р баг
26	Ууганцэцэг	ДЗ 8-р баг
27	Т.Уугантуяа	ДЗ 4-р баг
28	Ч.Мөнхсайхан	ДЗ 1-р баг
29	Б.Батням	ДЗ 7-р баг

30	Б.Батчулуун	Баяндалай
31	П.Оюу-Эрдэнэ	Баян-Овоо
32	Б.Цэрэндолгор	Булган
33	А.Нямцоо	Гурвантэс
34	З.Тэмүүлэн	Мандал-Овоо
35	Н.Болорчимэг	Манлай
36	Дамдин	Номгон
37	Я.Тогтох	Ноён
28	А.Золзаяа	Сэврэй
39	С.Сайханчулуун	Ханбогд
40	Дэлгэрмаа	Ханхонгор
41	С.Дэлгэрбат	Хүрмэн
42	Д.Ганболд	Цогт-Овоо
43	Ж.Дэмбэрэл	Цогтцэций

### ***В. Төв аймгийн 30-р тойрогт***

	<b>Нэр</b>	<b>Ажилласан сум багийн нэр</b>
44	Б.Саруул	Төслийн удирдагч
45	Ц.Оюун	Төслийн менежер
46	Х.Дуламсүрэн	Ажилтан
47	Б.Сумъяабазар	Зуунмод 4-р баг
48	С.Оюунсүрэн	Зуунмод 4-р баг
49	Г.Номунзаяа	Зуунмод 1-р баг
50	Б.Эрдэнэтуяа	Зуунмод 1-р баг
51	Х.Цолмон	Зуунмод 1-р баг
52	Ц.Хонгорзул	Зуунмод 4-р баг
53	Б.Баянцэцэг	Угтаал сум
54	Б.Жавзандулам	Цээл сум
55	Ц.Тайванбаяр	Заамар сум
56	Б.Мөнхзаяа	Баянчандмань сум
57	Я.Сонинтуяа	Сүмбэр сум
58	Т.Жаргалбаяр	Жаргалант
59	Ж.Отгонбат	Борнуур сум